# ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА

МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГИЙН

МХСН

№001

2018 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 12


5 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ХҮРГЭЕ!



## СУДАЛГААНД СУУРИЛСАН ХИЧЭЭЛ СУРАЛЦАХУЙГ ДЭМЖСЭН АРГА ЗҮЙН ХӨГЖИЛ

**ЭРХЭМ ЗОРИЛГО:**

Хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх замаар суралцахуйн чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулах

**НИЙГЭМЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ**

1. Боловсролын судалгаа, суралцахуйн судалгаа
2. Багш бэлтгэдэг их дээд сургууль болон ЕБС–ийн багш нар, судлаачдын хамтын ажиллагаа
3. Ажлын байран дээр багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа
4. Сургалт, судалгаа, мониторинг, зөвлөгөө, туршлага солилцоо
5. Гадаадын улс орнуудтай харилцах, хамтран ажиллах

Нийслэлийн 45 дугаар сургуулийн багш Д.Чимидцэрэн хичээл дээрээ

# МЭНДЧИЛГЭЭ

№ 001

Web: http://mals.mn/

## Мэндчилгээ



МХСН–ийн үүсэн байгуулагдсаны 5 жилийн ойн баярын мэндийг тус нийгэмлэгийг үүсгэн байгуулагчид, удирдах зөвлөлийн гишүүд, хичээлийн судалгааны үе үеийн эксперт, зөвлөх, хамтран ажилладаг сургууль байгууллага, багш сурган хүмүүжүүлэгчид болон гишүүд, дэмжигчиддээ өргөн дэвшүүлье.

МХСН–ийн 5 жилийн ойн өдөр 2006–2013 онд БСШУЯ ба олон улсын Жайка байгууллагын хэрэгжүүлсэн хоёр шатны төслийн үндсэн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх, багшлахуй ба суралцахуйн чанарыг ахиулах үндсэн арга хэрэгсэл болох Хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарсан хариуцлагатай ажлыг цаашид тогтвортой үргэлжлүүлэн авч яваа МХСН ТББ–ийн гишүүд, дэмжигчид Та бүхэн манлайлан ажиллаж байгааг тэмдэглэхэд таатай байна.

БМДИ болон МХСН үндэсний эксперт, зөвлөх, сургагч багш нар, гишүүд урьдын адил боловсролын шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хичээлийн судалгааны арга зүйг судлан хөгжүүлэх замаар суралцахуйн чанарыг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулах чиг үүргээ цаашид ч нэр төртэй биелүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

*Сайн үйлс бүхэн дэлгэрч*
*Санасан бүхэн сэтгэлчлэн бүтэх болтугай.*

**МХСН–ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ДОКТОР Н.ОЮУНЦЭЦЭГ**

## Мэндчилгээ



Зуу гаруй жилийн тэртээ Япон улсын бага сургуулийн багш нарын санаачилж үүсгэсэн хичээлийн судалгааны арга зүй өнөөдөр дэлхийн олон улсад түгэн дэлгэрээд байна. Энэ арга зүйг Монгол улсад таниулах, туршин хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх төслийн ажил Жайка байгуулллагын дэмжлэгийн дор зургаан жилийн хугацаанд 2006–2009, 2009–2013 гэсэн хоёр үе шаттай амжилттай хэрэгжсэн билээ.

"Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг" гэдэг нэгэн айл энэ төслийг үргэлжлүүлж, хичээлийн судалгааг Монгол улсын ерөнхий боловсролын сургуульд нутагшуулахаар өрхөө татаж, үүдээ сөхсөн өдрөөс хойш таван хаврыг угтаж, таван намрыг үджээ. Хүний насаар тоолбол тархины хөгжлийн оргил үе гэж хэлж болно. Байгууллагын хувьд ч хийж бүтээхээр зорьсныхоо суурийг босгож, хөгжүүлэх чигээ тогтоосон цаг үе байсан болов уу.

Хичээлийн судалгаа зөвхөн тухайн багшийн хичээлээ заах чадварыг өсгөөд зогсохгүй багш нарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, багш багшаасаа сурсан хамтын ажиллагааны чадвараа сурагчдадаа өвлүүлэхийн суурийг тавьж өгдөг гэж би ойлгодог. Яг л энэ бүхнийг амилуулж өөрийн хаана байгаагаа мэдэрч, хаашаа явахаа ухаарах түлхүүрийг атгуулдаг хичээлийн судалгааны давуу талыг багш бүрд хүргэхээр ажилласан таван жилийн баярын мэндийг дэвшүүлье.

Багшийн бие дааж  хөгжих, хамтран хөгжих зам чигийг заан чиглүүлэх үйлс тань өнөөдрийн өдрийг амжилтаар дүүрэн угтсан шигээ тав таван жилээр амжилт, ололтоо ахиулан, нэг ч багш хичээлийн судалгаагүйгээр хичээл зааж болохгүй гэсэн сэтгэлгээтэй болох өдөр ойрхон байгаа гэдэгт итгэж байна.

Боловсрол олгох үйл ажиллагааны тэргүүн фронтод ажиллаж, хийж байгаа ажлаа үр дүнд хүргэх боломжийг багш хүний гарт  нь атгуулж байдаг та бүхний хариуцлагатай үйлсэд амжилт ерөөе. Зааж байгаа хичээлдээ судалгаа дүгнэлттэй ажилладаг дадлаар дамжуулан, хүн бүр хийж байгаадаа эргэцүүлэл, бодолтой хандахын суурийг босгож монгол хүний өнөөгийн төрхийг дэлхий нийттэй хөл нийлүүлэхэд хичээлийн судалгаагаар дамжуулан гүйцэтгэх үүргийг тань илүү өргөнөөр төсөөлж байгаагаа илэрхийлэх ялдамд тийм сэтгэл зүрх танай байгууллага, ажилтнуудад тань байгааг харж, бахархаж байдгаа баярын энэ өдөр илэрхийлье.

***БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН ЗАХИРАЛ ДОКТОР Д.СҮРЭНЧИМЭГ***

## МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ

**ҮҮСЭЛ**

2013 оны 8 дугаар сарын 15-16-нд БМДИ ба БСШУЯ ба олон улсын Жайка байгууллагын төслийн баг хамтран зохион байгуулсан "Хүүхдийн хөгжил хичээлийн судалгаа" сэдэвт үндэсний ЭШ-ий анхдугаар бага хурлаар ашгийн бус ТББ "Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (Mongolian Association of Lesson Study)"-ийг байгуулахаар шийдвэрлэжээ. Үүсгэн байгуулагчдын анхдугаар хурлыг хийж тус нийгэмлэгийг ТББ хэлбэрээр зохион байгуулж, дүрмийн төсөл, эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлсон тогтоол гаргасан 2013 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийг МХСН үүсэн байгуулагдсанаар тогтжээ.

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИД:



**Ноокоогийн ОЮУНЦЭЦЭГ**



**Бадамсамбуугийн ХИШИГБАЯР**



**Иший ТЭЦҮЯА**



**Сузуки САЯАКА**



**Гочоосүрэнгийн НОРЖМАА**



**Төмөрбаатарын ГАНБААТАР**



**Чойжилсүрэнгийн НЯМГЭРЭЛ**



**Мөнхөөгийн ГАНБАТ**



**Мөнхжаргалын БААСАНХҮҮ**

## ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Судалгааны ажил.** Хичээлийн судалгааны мэргэжилтэн (эксперт, үндэсний зөвлөх, сургагч багш) болон сургууль багш нар хамтран сургуульд суурилсан болон судлагдахуунд суурилсан судалгааг хөгжүүлж байна. Тэдгээр судалгааны ажлыг МУИС, МУБИС болон зарим багш бэлтгэдэг дээд сургуулийн судлаачид хичээлийн судалгааг хийх, багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг энэ чиглэлд хөгжүүлэх үйл ажиллагааг голлон гүйцэтгэж үр дүнг илтгэл, өгүүлэл, магистрын дипломын ажил, докторын диссертаци зэрэг эрдэм шинжилгээний бүтээл хэлбэрээр хэлбэршүүлдэг. БМДИ, МХСН хамтран жил бүр зохион байгуулдаг "Хүүхдийн хөгжлийг дэмжих багшлах аргазүй" сэдэвт онол практикийн бага хурал нь судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж



чиглүүлэхийн зэрэгцээ ЕБС-ийн болон их, дээд сургуулийн судлаачид, боловсролын салбарын удирдах ажилтнуудын туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх ажлын шинэлэг хэлбэр, судалгааны талбар болж ирлээ. "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй" сэдэвт онол практикийн бага хурал 2013 оноос эхлэн "Боловсролын чанар нь хичээлийн чанараас, хичээлийн чанар нь хичээлийн судалгаанаас" уриан дор тогтмол явагдаж ирлээ. Онол практикийн дөрөвдүгээр бага хуралд "Хүүхдийн хөгжлийн судалгаа", тавдугаар бага хуралд "Тусгай хэрэгцээт боловсрол"-ын гэсэн шинэ чиглэл нэмэгдсэн юм.

## СУРГАЛТ

МХСН-ийн нэг томоохон үйл ажиллагаа бол дотоодын болон гадаадын сургалт зохион байгуулах зорилт юм. Энэ зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дотоодод захиалгат сургалт, зочны хэлэлцүүлэгт сургалт, төрөлжсөн сургалт, мониторинг зөвөлгөө өгөх, Mals.mn сайтаар дамжуулан мэдээлэл түгээх, харилцан туршлага солилцох зэрэг хэлбэрээр үйл ажиллагаа явуулж ирлээ. Японд жил бүр "Хичээлийн судалгааны арга зүй" сургалтыг зохион байгуулж байна.

**ЗАХИАЛГАТ СУРГАЛТ.** МХСН-ийн хичээлийн судалгааны үндэсний эксперт, зөвлөх, сургагч багш нар нийслэл, орон нутаг, сургуулийн захиалгаар сургалт хийж байна.

**ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ СУРГАЛТ.** Хичээлийн судалгааны өлгий нутаг Японы профессор багш нар, сайн дурын ажилтнууд цуврал лекц, хэлэлцүүлэгт сургалтыг явуулж ирлээ.

**ЯПОН ДАХЬ СУРГАЛТ.** Төслийн нэг үндсэн үйл ажиллагаа байсан "Хичээлийн судалгааны арга зүй" сэдэвт Японд дахь сургалтыг МХСН уламжлан авч 2014 оноос эхлэн жил бүр зохион байгуулж ирлээ.

**ТӨРӨЛЖСӨН СУРГАЛТ.** МХСН хичээлийн судалгааны үндэсний эксперт, үндэсний зөвлөх, үндэсний сургагч багш, Бүсийн сургагч багшийн эрх олгох төрөлжсөн сургалтын хөтөлбөрийг холбогдох байгууллагаар батлуулан 2016 оноос сургалтаа эхлүүлсэн. нь Өөрийн идэвхтэй, практик үйлээр суралцаж шаардагдах мэдлэг, чадвараа эзэмшиж, тодорхой шалгууруудыг хангасан нөхцөлд эрхээ авдаг нь энэ хөтөлбөрийн онцлог юм (mals.mn сайтаас шалгуурыг үзнэ).

**ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ӨДӨРЛӨГ.** Хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх үе шатны нэг ажил нь хичээлийн судалгааны өдөрлөгийг сургууль, дүүрэг, бүс нутгийн хэмжээнд зохион байгуулж туршлагаа солилцох, түгээн дэлгэрүүлэх ажил юм. Монгол улсад анх удаа Хөвсгөл аймгийн "Дэлгэрмөрөн цогцолбор" сургууль Хичээлийн судалгааны өдөрлөгийг 2017 оны 11 дүгээр сарын 29-нд зохион байгуулж анхдагчийн гэрчилгээ авсан юм.



Төслүүдийг ЖАЙКА, түүний СТГ болон БСШУЯ, түүний БДБГ хамтран хэрэгжүүлсэн.

# СУДАЛГААНД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН БОЛОН **СУРГАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭ СОЁЛ**

**Сурган хүмүүжүүлэх ухааны доктор, профессор Н.НЭРГҮЙ**

БСШУЯ нь Японы Олон улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран "Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил (2006-2009)" ба "Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь (2010-2013)" гэсэн хоёр шаттай 6 жилийн үндэсний хэмжээний төслийг амжилттай хэрэгжүүлсэн билээ. Эдгээр төслийг хэрэгжүүлэх үндэсний багт миний бие эрхлэх ажлынхаа үндсэн чиг үүргийн хүрээнд бодлогын зохицуулагчийн үүрэг хүлээн ажилласан.

Боловсролын тогтолцооны амин сүнс болох хувь хүний суралцах үйлд төвлөрч юунд суралцахын оновчлохоос энэ тогтолцооны хөгжил бүхэлдээ хамаарах байсан тул нэн түрүүнд шийдвэрлэх ёстой тулгамдсан асуудал бол боловсролын чанарын баталгааг хангах зориулалттай цогц чадамжинд суурилсан боловсролын шинэ стандарыг боловсруулан баталж, хэрэгжүүлэх явдал байлаа. Иймээс 2002 онд бага, дунд боловсролын стандарт ба киррикюлим (Сургалтын хөтөлбөр)-ийг шинэчлэх үзэл баримтлалыг, улмаар 2002-2004 онд цогц чадамжид суурилсан 20 гаруй стандартыг тус тус боловсруулан баталж, 2005-2006 оны хичээлийн жилээс үндэсний хэмжээнд мөрдөж эхэлсэн юм.

Боловсролын шинэчлэлийн зорилт, хэрэгжилтийн хувь заяа нь анги танхимд сургалт явуулж байгаа багшийн мэргэжил арга зүйн хөгжлийн түвшин төдийгүй сургалтын технологийн соёлоос шууд хамаарах тул БСШУЯ-аас багшлах арга зүйн хөгжлийн чиглэлээр олон төсөл хөтөлбөрүүдийг дэмжин хэрэгжүүлж ирсэн. Тэдгээрээс хамгийн үр өгөөжтэй, тогтвортой хэрэгжсэн төслүүдийн нэг нь БСШУЯ ба ЖАЙКА-ийн хамтран хэрэгжүүлсэн дээр дурьдсан харилцан уялдаатай төслүүд юм.

1995-2006 оныг хамарсан боловсролын орчлын нэгдсэн үнэлгээний үр дүнд тулгуурлан Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг боловсруулж, хөгжлийн стратегүүдээ нарийвчлан боловсролын салбарт оруулах материаллаг болон оюуны хөрөнгө оруулалтууд нэгдсэн зохицуулалттай болоод байсан цаг үед дээрх төслүүдийн хэрэгжсэн онцлогтой.

Тэгээд ч БСШУЯ нь ЖАЙКА-тай хамтран "Залуучуудын хөтөлбөр", "Удирдах ажилтны чадавхийг дээшлүүлэх", "Багш нарын мэргэжил дээшлүүлэх", "Арга зүйн хөгжлийн төвүүд байгуулах" зэрэг төслүүдийг хэрэгжүүлж, агуулгын хувьд гүнзгийрсэн, цар хүрээний хувьд далайцтай шинэ төслүүд хэрэгжүүлэх урьдач нөхцөлийг хангасан байлаа. Түүнчлэн төслийн бэлтгэл ажлын хүрээнд төслийн хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх, төслийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, загвар сургуулиуд сонгох, эрх зүйн орчин бүрдүүлэх ажлуудыг гүйцэтгэсэн. Ингээд 2006 оны 05 сарын 10-нд Засгийн газрын холбогдох яамд болон ЖАЙКА-ийн хооронд "Хамтран ажиллах ойлголцлын бичиг" байгуулснаар төсөл маань албан ёсоор эхэлсэн юм.

"Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил" хэмээх эхний шатны төслийн зорилго нь хүүхдийн жам ёсны суралцахуйг хичээлийн судалгаа хэмээх тусгай арга хэрэгслээр хэрхэн дэмжих арга зүйг боловсруулан туршиж, хичээлийн соёлын шинэ үрийг гарган авахад оршиж байсан бол "Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь" хэмээх хоёр дахь төслийн зорилго нь энэхүү бүтээсэн арга зүйгээ Монгол Улсад үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлж, хичээлийн соёлын шинэ үрээ сургалтын технологийн шинэ менежмент болгон соёолуулахад тус тус оршиж байв.

Дээрх төслүүдийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газар болон БСШУЯ-ны манлайлал өндөр байсныг энд дурьдах нь зүйтэй. Тухайлбал, Засгийн газраас ЖАЙКА-тай 2008 оны 5 дугаар сард байгуулсан "Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөр"-ийн зээлийн хэлэлцээрт тус төслүүдтэй холбоотой заалтуудыг тусган хэрэгжүүлсэн.

Төсөл хэрэгжсэнээр хэрэглэгдэхүүний судалгаа (Kenzo Kenkyu), хичээлийн судалгаа (Jyugyo Kenkyu) буюу олон улсад "Lessons study" хэмээн нэрлэдэг багш нар хамтран хичээлдээ бэлтгэх, хичээлээ заах, заасан хичээлээ хэлэлцэж сайжруулах үе шат бүрийг судалгаанд суурилан хэрэгжүүлдэг Японы сургалтын инновац нь Монголын бага, дунд боловсролын хам нөхцөл (стандарт, хөтөлбөр, сурах бичиг, багш, сургууль)-д нутагшин нэвтэрсэн юм.





Эхний шатны төсөл амжилттай хэрэгжиж дууссан тухай МҮТ–ээр мэдээлсэн баг. 2009.05.29

Монгол хүүхдүүдийн суралцахуйг хичээлийн судалгаа болон сургалтын технологийн шинэ менежментээр дэмжих шинэ арга зүй бүтээхэд үнэтэй хувь нэмэр оруулсан Та бүхэндээ тарьсан үр, соёолсон ололтоо тэтгэж, их амжилт гаргахын ерөөл дэвшүүлье.

*Дурсамж*

# ЯПОНЫ JICA БАЙГУУЛЛАГЫН ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР ХЭРЭГЖСЭН ТӨСЛИЙН ЭХНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Доктор Б.БУРМАА**
**Доктор Ц.ДАРЖАА**

Төсөлтэй холбоотой анхны уулзалтууд: Одоогоос 13 жилийн тэртээ 2005 оны 12-р сарын 05-ны өдөр Япон улсын JICA байгууллагын монгол дахь төлөөлөгчийн газраас өөрийн байрандаа (Бодь цамхаг 709 тоот) монголын багш нарын сурган хүмүүжүүлэх арга зүйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах боломжийн талаар санал солилцох ярилцлагыг зохион байгуулсан юм. Энд манай боловсролын салбарын хэд хэдэн байгууллагын төлөөлөл уригдсан байсан бөгөөд Д.Доёд багш үүрэг өгсөний дагуу МУИС-ийн МДССТ-ийг төлөөлж проф. Б.Бурмаа, Ц.Даржаа нар оролцож байв.



Тун удалгүй  тухайн үед БСШУЯ -ны зөвлөхөөр ажиллаж байсан Япон улсын иргэн проф. Тацуо Коиде гуай манай МДССТ-ийн үйл ажиллагаатай танилцах хүсэлт тавьсаны дагуу бид 2006 оны 03 сарын 08-д түүнийг хүлээн авч уулзсан юм. Манай төв математик ба байгалийн ухааны дидактикийн чиглэлээр сургалт, судалгааны ямар үйл ажиллагаа явуулдаг болон монголын бага, дунд боловсролын салбарт хэрэгжиж байгаа боловсролын стандартын үзэл баримтлалыг боловсруулах, турших, хэрэгжүүлэх үйлд хэрхэн оролцож ирсэн талаар бид дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Харин  Койде багш бидэнд Японы багш нарын хичээл сургалтын ажлын туршлагаас суралцан хамтран ажиллах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх сонирхолтой хамтлагуудын талаар мэдээлэл цуглуулж  байгаа тухайгаа танилцуулсан юм. Ярилцлагын эцэст Койде багш бидэнд хандаж математик байгалийн ухааны хичээлийн чиглэлээр хамтран ажиллах  сонирхолтой бол БСШУЯ-аас JICA байгууллагатай хамтран хэрэгжүүлэх төсөлд хэрхэн оролцохыг тусгасан анхны хувилбарыг боловсруулахыг санал болгож, анхаарах асуудлуудын талаар зөвлөмж өгсөн. Дэлхийн түвшинд математик, байгалийн боловсролын чанарыг үнэлдэг судалгаанд сурагчид нь дээгүүр байранд ордог японы багш нараас суралцах боломж гарах магадлалтай энэ төсөлд ихээхэн найдлага тавьж, хэдийгээр хичээл сургалтын ажил их байсан боловч төслийн анхны хувилбарыг монгол, япон хэл дээр боловсруулж товлосон хугацаанд нь хүлээлгэн өгсөн. Койдо багш бидний боловсруулсан хувилбартай танилцсаны дараа 2006 оны 05-р сарын 19-нд БСШУЯ-ны дэд сайдын өрөөнд болсон уулзалтанд хүрэлцэн ирэхийг урьсан. Уулзалт дээр Койдо багш бидний боловсруулсан төслийн үндэслэлийг танилцуулж, өөрийн зүгээс талархан хүлээн авч байгаагаа дурьдаад цаашид илүү боловсронгуй болгох талаар дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна гэдгээ мэдэгдсэн.  Уулзалтанд оролцсон боловсролын яамны дарга "Японтой хамтрах энэ төслийг бид өөр сургуульд өгөхөөр төлөвлөж байгаа. Бурмаа багш та яагаад сэргэлэнтээд байна?" гэж надаас асуухад нь би "та нар чинь өөрсдөө биднийг зах зээлийн өрсөлдөөнт нийгэмд овсгоотой бай гээд байгаа биз дээ" гэж хэлчихээд дотроо жаахан эмээж суулаа. Ярилцлагын эцэст яамны дарга "Энэ төслийн асуудлыг бүхэлд нь манай яам шийднэ. Гэхдээ танай төвийг боломжийн хэмжээнд оролцуулахыг бодно" гэж нөхөрсөгөөр хэлсэн учир Даржаа бид хоёр хөлс мөнгөгүй зүтгэсэн ажил маань үр дүнд хүрч магадгүй юм байна гэсэн горьдлоготойгоор нилээд баяртай буцаж байсан юм.



Жайка-ийн төслийн эхлэл: Төслийг БСШУЯ-ны бага, дунд боловсролын газар хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд төсөлд хамрагдсан багуудын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх гол үүргийг тус газрын ахлах мэргэжилтэн доктор Н.Нэргүй гүйцэтгэж байсан. Төсөл хэд хэдэн салбартай байх талаар шийдвэр гарч, байгалийн ухааны багийг МДССТ, матемтикийн багийг МУИС, МУБИС-ийн багш нарын бүрэлдэхүүнтэй хамтлаг, өөр гурван багийг (мэдээлэл зүй, төсөлт хичээл бага ангийн "хүн орчин"-хичээл) МУБИС хариуцан ажиллах болсон. 2006 оны 10-р сарын 09-өөс төсөл "СУРАЛЦАГЧИЙН СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ХӨГЖИЛ" нэртэйгээр хэрэгжиж эхэлсэн.

ТӨСӨЛ-ӨНӨӨДӨР
№ 001
Web: http://mals.mn/

**Б.ХИШИГБАЯР**
МХСН-ИЙН ТЭРГҮҮН, ДОКТОР



# ХИЧЭЭЛД ДУРТАЙ, ХҮҮХДЭД ХАЙРТАЙ БОЛСОН ОН ЖИЛҮҮД МИНЬ

2010-2013 онд төслийн хоёр дахь шатанд Япон зөвлөхүүдийн багт орж ажилласан нь миний хувьд “хамгийн үнэ цэнэтэй боловсрол эзэмшсэн их сургууль” байлаа.

Япон зөвлөхүүдтэй хамт хичээлд ажиглалт хийж, тэдний санал, зөвлөмжийг сонсоно гэдэг бидний хувьд хөгжих маш том боломж байсан. Өмнө нь их сургуульд багшилж байсан миний хувьд тэдний зөвлөмж “шар тос” л гэсэн үг. Энэ зөвлөхүүдийн ачаар хүүхдийг “хайрлах, эрхлүүлэх”, “сургах, хөгжүүлэх” зэргийн ялгааг ойлгож хичээлд дуртай, хүүхдэд хайртай болсон доо.

Монголын талаас төслийг голлон удирдаж байсан Н.Нэргүй доктор маань “энэ бол ярьдаг бус хийдэг төсөл” гэж онцолж байсан нь багш нар “хийнгээ суралцах” арга барилыг эзэмшихэд чухал дэмжлэг болсон. ЕБС-ийн зарим сургууль ”ЖАЙКА-гийн хичээлийн судалгаа” шиг төсөл дахин хэрэгжээсэй, тэр хэрэгтэй төсөл байсан шүү” гэж хэлэхийг сонсох нь нийгэмлэгийн үйл ажиллагааг өргөжүүлэх урам, зориг өгсөн билээ.

Төсөл дуусаад 2013 онд хичээлийн судалгааны нийгэмлэг байгуулсан Монголын жишээ олон улсад туршлага болохуйц үйл ажиллагаа болсон юм. Нийгэмлэгийн үйл ажиллагааг Япон талаас Иший сан, Сузүки сан, Фүкүчи багш зэрэг хүмүүс үргэлжлүүлэн дэмжихийн зэрэгцээ Монголын талаас БМДИ нь өнөөг хүртэл хамтран ажиллаж байна. Төслийн эхний шатанд арга зүйн багийн ахлагч, төслийн хоёрдугаар шатанд яамны хэрэгжилтийн зохицуулагчаар ажилласан “Ноокоо” гэж нэрлэгдсэн, олондоо хүндтэй Оюунцэцэг багш маань нийгэмлэгийг мэргэжлийн байгууллагын хэмжээнд удирдаж байна.

“Хичээлийн судалгаа” гэж нэрлэгддэг төслийн дараа ЖАЙКА-гаас “Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх” төсөл 2016-2019 хэрэгжүүлж байна. Уг төслөөр мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалтын хөтөлбөрийн менежментийг сайжруулах зорилготой 10 жилийн төлөвлөгөө, үйл ажиллагааны удирдамж боловсруулаа. Ийнхүү, төслийн багийн Япон, Монгол талын гишүүд бид “атгасан гар” шиг эвтэй байж их ажлын эхийг тавьсан, энэ ажил маань олны дэмжлэгээр үргэлжилж байгаад маш их баяртай байна.

Өнгөрсөн хугацаанд хамт ажилласан Япон, Монгол багш нартайгаа “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг”-ийн шугамаар хэзээ ч тасрахгүй нандин холбоотой үргэлжлүүлэн ажиллаж байгаа нь Монголын хүүхдүүдийн маань ирээдүй гэрэлтэй байх сүүн цагаан зам билээ. Бүгдээрээ хамтдаа хичээцгээе.



**Ж.НАРАНТУЯА** (ДОКТОР)

# ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА: БИ ба БИД

Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн, залгамж холбоо бүхий “Суралцагчийн суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил”, “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх”, “Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх” төслүүд нь ерөнхий боловсролын сургуулийн багш, сургуулийн удирдлага, судлаач болон их, дээд сургуулийн багш нарыг хүүхдийн хөгжлийг дэмжих, багшийн арга зүйг хөгжүүлэх нэгэн зорилгын дор нэгдэж, нэгэн зүгт харж, гар нийлсэн, бүтээлч баг болгосон анхны төслүүд билээ.

Боловсролын шинэ стандартад нийцсэн хүүхдийн хөгжлийг дэмжих шинэ арга зүй боловсруулах зорилго бүхий “Суралцагчийн суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн (2007-2009 он) эхлэлийг тавихад Н.Нэргүй багшийнхаа хамтаар оролцож, МУИС-ийн "Байгалийн ухааны боловсролын сорил-туршлага хөгжлийн төв", МУБИС-ийн "Бага боловсролын дидактик сургалт судалгааны төв", "Математик боловсролын туршилт судалгааны төв", "Мэдээлэл зүйн боловсролын арга зүйн төв"-ийн багш, судлаачид болон загвар сургуулиар сонгогдсон 9 сургууль (Нийслэлийн 45-р сургууль, 97-р сургууль, Сэтгэмж цогцолбор, Дорнод аймгийн 5-р сургууль, Хан-Уул цогцолбор, Матад сумын сургууль, Сэлэнгэ аймгийн 1-р сургууль, 4-р сургууль, Хушаат сумын сургууль)-ийн багш, удирдлагатай хамтран ажиллаж, 8 судлагдахуун (Физик, Хими, Хүн-Орчин, Хүн-Байгаль, Бага ангийн математик, Дунд ангийн математик, Мэдээлэл зүй, Төсөлт ажил) тус бүрээр "Багшид зориулсан арга зүйн зөвлөмж", "Хичээлд мониторинг хийх зөвлөмж", "Зөвлөмж боловсруулах гарын авлага" боловсруулахад хамтран ажиллах завшаан тохиосонд баярлаж явдаг. БИ байсан бол БИД болж хамтран хичээлд бэлддэг, заадаг, судалдаг, үр дүнгээ хэлэлцдэг, харилцан суралцдаг болсон нь энэ төслийн хамгийн том үр дүн байсан юм.

Бидний хамтын ажиллагаа үр шимээ өгч, үр дүнтэй болсны тод жишээ бол төслийн дараагийн шат буюу “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” (2010-2013) төсөл юм. Төслийн энэ шатанд төслийн Үндэсний багийн зохицуулагчаар ажиллаж ЕБС-ийн удирдлага, багш нарт зориулсан багшлах арга зүйг шинэчлэхэд чиглэсэн сургалтын модуль боловсруулж, "Хичээлийн судалгаа" болон сургалт зохион байгуулахад нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг болон Булган, Завхан аймгуудын Ирээдүй цогцолбор, 12-р сургууль, 67-р сургууль, Булган аймгаас 1-р сургууль болон Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Гурванбулаг сумын сургууль, Завхан аймгаас Чандмань Эрдэнэ цогцолбор, Тосонцэнгэл, Сонгино, Баянтэс, Завханмандал, Шилүүстэй сумын сургууль зэрэг 14 сургуулийн хамт олон, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, МУИС, МУБИС-тэй БИД нэг баг болж чадсан.

*Дурсамж*

# Төслийн хэрэгжилт Монголд

**Н.ОЮУНЦЭЦЭГ** (ДОКТОР)

Монгол Улсын БСШУЯ, Сангийн яам болон Монгол дахь Японы олон улсын хамтын ажиллагааны Жайка байгууллагын хооронд 2006 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцүүлгийн үр дүнд “Суралцагчдын суралцахуйг дэмжсэн арга зүйн хөгжил” төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Бэлтгэл үед байгуулагдсан МУИС, МУБИС-ийн арга зүйн хөгжлийн дөрвөн төвийг түшиглэн дээд болон ЕБС-ийн багш нар оролцсон найман судлагдахууны мэргэжлийн багууд шинэ арга зүйг хамтран бүтээж загвар сургуулиуд дээр турших ажил эхэлсэн.

Төслийн эхний шатанд арга зүйн чиглэлээр багш нарт зориулсан нийт 400 хэвлэлийн хуудас бүхий 27 зөвлөмж ном, 8 DVD-ийг бэлтгэн гаргаж, хот, хөдөөгийн бүх сургууль, багш нарт арга зүйн зөвлөмжийг судлан хичээлдээ турших боломж олгохоор нийт 32400 хувь хэвлэж бүх сургууль болон боловсролын байгууллагуудад хүргэсэн нь өнөөдөр ч эрэлт хэрэгцээ ихтэй байна.



Төслийн II шатанд СХД–ийн Ирээдүй ЦС, 12, 67, Булган аймгийн төвийн 1, Хишиг-Өндөр, Сэлэнгэ, Гурванбулаг, Хутаг-Өндөр сумын сургууль, Завхан аймгийн Чандмань-Эрдэнэ ЦС, Шилүүстэй, Сонгино, Баянтэс, Тосонцэнгэл, Завханмандал сумын сургуулиуд загвар сургууль болж ажилласан. Яам, мэргэжлийн багийн төлөөлөл бүхий 8 хүнтэй баг, загвар сургуулийн 17 хүнтэй багийн сургалтыг 2010 оны 10 дугаар сард Япон улсад зохион байгуулсан. Мөн 2011-2012 онд нийт 43 хүн Японд, 2012 онд боловсролын удирдах байгууллага болон загвар аймгийн төлөөлөл болох 12 хүн Индонезид туршлага солилцох айлчлал хийсэн байдаг.

Төслийн энэ шатанд Камата Масахиро, Такахата Хироши, Фүкүчи Акитэрү, Мацүүра Шюү нар Япон талын зөвлөх багшаар ажилласан. Төслийн үр дүнд багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэхэд хэрэглэх тус бүр 10 хэвлэлийн хуудас судлагдахууны 9 модуль, тусгай зориулалттай 3 гарын авлага, нийт 12 бүтээл туурвиж, тус бүрийг 800 хувь хэвлэн сургууль багш нарт хүргүүлсэн.

2012 оны 9 сард байгуулагдсан БМДИ төслийн хамтран ажиллагч байгууллага болсон учир төслийн хугацааг 6 сараар сунгаж 2013 онд БМДИ (10 хүн) ба бусад төлөөлөл бүхий 21 хүний сургалтыг Японд зохион байгуулж хүний нөөцийг бэлтгэсэн.

2013 онд төслийн хоёрдугаар шат дуусахад төслийн үндсэн үйл ажиллагааны тогтвортой байдлыг цаашид хангах, багшлахуй ба суралцахуйн чанарыг ахиулах үндсэн арга хэрэгсэл болох хичээлийн судалгааг цаашид хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарсан билээ. Энэхүү эрэлт хэрэгцээг хангах, үйл ажиллагааг нь цаашид авч явах нэр хүндтэй, хариуцлагатай үүргийг төрийн байгууллага БМДИ ба ТБ байгууллага МХСН хүлээн авч өнөөдөр хүртэл амжилттай хамтран ажиллаж байна.

Төслийн үйл ажиллагааг амжилттай удирдсан БСШУЯ-ны үе үеийн удирдлага, төслийн зохицуулагчид, ажилтан, Японы Кооэй” судалгааны хүрээлэн, судлаач Тэцуя Иший, Саяака Сузуки болон мэргэжлийн баг, загвар сургуулийн удирдлага багш нар болон багшлахуйн арга зүй хөгжлийг таньж мэдэх болсон, хэрэгцээ шаардлага нь өсч байгаа энэ цаг үед багшлахуйн аргазүйг хөгжүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж яваа бүх гишүүд, дэмжигчид, БМДИ-ийн хамт олонд амжилт хүсч, МХСН үүсэн байгуулагдсаны таван жилийн ойн мэндийг хүргэе.

# СУДЛАГДАХУУНЫ БАГ

Web: http://mals.mn/

№ 001

МАТЕМАТИК(БАГА) БАГИЙН АХЛАГЧ **О.ЧУЛУУНЦЭЦЭГ**



## “ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА”-ТАЙ ТАНИЛЦСАН ОН ЖИЛҮҮД

Багшийн сургуулийн бага боловсролын дидактикийн сургалт судалгааны төвийн үйл ажиллагааг дэмжих, сайжруулах зорилгоор 2006 оны 5 дугаар сараас “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төсөл гурван жилийн хугацаатайгаар орж ирсэн нь тус төвд ажиллаж байсан багш нарыг баярлуулж билээ. Манай төвийн төсөлт ажил (Ц.Наранцэцэг), математик (О.Чулуунцэцэг), хүн-байгаль (Г.Нэргүй) хичээлүүд уг төсөлд хамрагдсан нь эдгээр хичээлүүдийн арга зүйг шинэчлэх суралцагчдын бие даан суралцах чадварыг илрүүлэн хөгжүүлэх, сурагч төвтэй сургалтыг түгээн дэлгэрүүлэх таатай боломжийг олгосон. Цаашилбал Монгол улсын боловсролын хөгжлийг өөрчлөн шинэчлэх зорилгоор хүүхдийн хөгжлийг дэмжих шинэ арга зүйг бий болгох хүндтэй үүрэг бидэнд оногдсон билээ.

МУБИС, МУИС-ийг эрдэмтэн, судлаач, арга зүйч багш нар болон ЕБС-ийн бүтээлч дайчин, шантаршгүй багш нартай хамтран ажилласныг мартах аргагүй. Гурван жилийн хугацаанд тодорхой үе шаттай нарийн төлөвлөгөөний дагуу Японы Гакүгэйн их сургуулийн олон багш, профессорууд болон математикийн багш Х.Такахата бидэнд үнэтэй зөвөлгөө өгч хамтран ажиллаж байлаа. Төслийн зохицуулагч Т.Иший ба орчуулагч Тогосоо, Бурмаа, Норжмаа нар бидэнтэй мөр зэрэгцэн ажиллаж харилцан туслалцаж байв. Японы багш нарын арга зүйгээ сайжруулж ирсэн олон жилийн туршлага болох “Хичээлийн судалгаа”, “Хичээлийн бэлтгэл судалгаа” гэсэн шинэ ойлголтыг мэдэх гэж, эзэмших гэж бид цөм хамтдаа цаг хугацааг алдалгүй ашиглан, ядрах зүдрэхийг мэдэхгүй шаргуу ажилласны дүнд манай баг гурван цуврал зөвлөмж бүтээсэн.

Бодит юмыг загварчлан тооцоолох үйлд хүүхдийг сургах арга зүй (нэмэх хасах үйлдэл)-I, Бодит юмыг загварчлан тооцоолох үйлд хүүхдийг сургах арга зүй (үржих хуваах үйлдэл)-II, Хийж, бүтээх, зурах, дүрслэх үйлээр дамжуулан математикийн агуулгыг эзэмшүүлэх арга зүй (хэсэг ба бутархай)- III гэсэн зөвлөмжүүдийг боловсруулсан.

Хичээлийн судалгааны ачаар ЕБС ба Их дээд сургуулиудын багш нарын хамтын ажиллагаа сайжирч, байгалийн ухааны хичээлүүдийн арга зүйд бодитой өөрчлөлт шинэчлэл гарсаар байна.

## “МАТЕМАТИК (ДУНД)”



2006-2009 онд хэрэгжсэн төслийн нэгдүгээр шатнаас эхлэн математик дунд ангийн баг тогтвортой үйл ажиллагаа явуулж ирснийг эргэн дурсахад таатай байна.

Манай багийг тухайн үеийн төсөл хэрэгжүүлэхэд голлон оролцож байсан МУБИС, МУИС-ийн багш нар, мөн ЕБС-ийн багш нар хамтран бүрдүүлж байлаа. Төслийн эхний жил математикийн багийн хувьд анх удаа хичээлийн судалгаа хийх арга зүйд хамтран суралцаж эхэлж байлаа. Тус багт Япон зөвлөх багшаар Токио Гакүгэй Их сургуулийн математикийн профессор Хироши Такахата, орчуулагчаар Г.Тогосоо нар мөн хамтран ажиллаж байв. Багийн бүх гишүүд хамтран дунд ангийн математикийн хичээл бэлдэж, 45, 97, 46 дугаар сургуулиудад ээлжлэн зааж, ажиглалт хийж, хэлэлцэн сайжруулах үйл ажиллагааг эхний улирлаас эхлэн тогтмол явуулж байлаа. Энэ бол их дээд сургууль, ЕБС-ийн багш нар хамтран хийсэн хамгийн анхны томоохон, урт хугацааны, үр дүнтэй хамтын ажиллагаа байлаа.

Математикийн багийн хувьд “Хүүхдээр математикийн хялбар мэдлэг бүтээлгэх арга зүй” 2007 он, “Сурах үйлийн баримжаагаар суралцахуйг дэмжих арга зүй” 2008 он, “Хүүхдээр асуудал шийдүүлэх арга зүй” 2009 он гэсэн 3 зөвлөмж боловсруулсан.

Математикийн дунд ангийн багийн арга зүй, онцлогийг харгалзан төслийн багийн зүгээс хичээлийн судалгаа гэж юу болохыг тодорхой жишээн дээр харуулсан DVD хичээл хийх санал тавьсны дагуу бага ангийн математикийн багш нартай хамтран уг ажлыг хийж гүйцэтгэсэн.

Математик боловсролын хөгжлийн чиг хандлага, математик суралцах болон багшлах үйл ажиллагааг судлан, математик сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн арга зүйн туршилт, судалгаа тогтмол явуулах, үр дүнг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий Математик боловсролын туршилт судалгааны төвийг 2004 онд МУБИС-ийн захирлын тушаалаар байгуулж байсан. Энэхүү төвийг байгуулахад Япон улсын JICA байгууллага ихээхэн туслалцаа үзүүлсэн.

## “Хүн-Орчин”



БСШУСЯ, Жайка Олон улсын байгууллагын хамтарсан 2 үе шаттай хэрэгжсэн төслийн хүрээнд МУБИС-ийн Багшийн сургуулийн Бага боловсролын байгалийн ухааны дидактикийн төв, Байгалийн ухааны сургуулийн багш нарын хамтарсан баг ЕБС-ийн 1-3 дугаар ангид үзэх “Хүн орчин” хичээлийн тодорхой бүлэг сэдвүүдийг заах арга зүйн зөвлөмж болон багшид зориулсан модуль, CD хичээлийг боловсруулсан.

Төслийн 1 дүгээр шатанд “Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй” – 2 дугаар анги (Сэдэв: Ургамал бидний орчин), “Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй” – 3 дугаар анги (Сэдэв: Манай орны байгаль), “Хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулах арга зүй” – 1 дүгээр анги (Сэдэв: Миний гэр, сургуулийн орчин) гэсэн зөвлөмжийг боловсруулсан.

Төслийн эхний жилд багийн ахлагчаар МУБИС-ийн Багшийн сургуулийн багш Г.Нэргүй, 2 дахь жилээс Э.Мөнгөнтулга, гишүүдэд А.Бямба, Г.Пунсалпаамуу, Б.Баярчимэг, Ч.Оюунгэрэл, Б.Нарангэрэл нар, 2 дугаар үе шатанд багийн ахлагчаар Э.Мөнгөнтулга, гишүүдэд: Г.Нэргүй, Ц.Пагмасүрэн, П.Алтанцэцэг, Д.Энхтуяа нар ажиллаж “Хүн орчин” хичээлийн “Багшлахуйн хөгжил” модулийг боловсруулсан.

Төслийн хугацаанд бидэнтэй японы Токио Гакүгэй Их сургуулийн профессор А.Фүкүчи, М.Камата, М.Сайкава нар хамтран ажиллаж үнэтэй зөвлөгөө, тусламж үзүүлсэн. Мөн монголын эрдэмтэн профессор Д.Улам-Оргих, С.Эрдэнэцэцэг нар санал, зөвлөмж өгч хамтран ажилласанд талархалтай байдаг.

## “Хүн байгаль”



Төсөл эхлэхэд МУИС-ийн МДССТ-ийн багш Б.Бурмаа, М.Ганбат (физик), Ц.Даржаа, Н.Оюунцэцэг, Ч.Нямгэрэл (хими), М.Алтанцэцэг (биологи), Г.Юмчмаа (газарзүй) нар хамтран бага боловсролын "Хүн байгаль” хичээлээр дамжуулан сорил туршилтаар мэдлэг бүтээх аргазүйг нэвтрүүлэн улмаар байгалийн ухааны судалгааны аргатай танилцуулж, суралцагчдын сурах үйлийг дэмжин нийтэд түгээн дэлгэрүүлэхээр хөтөлбөр зөвлөмж боловсруулан Улаанбаатар хот болон Дорнод, Сэлэнгэ аймгийн загвар 9 сургуульд туршиж эхэлсэн юм.

“Монгол улсын хүүхдийн хөгжлийг дэмжих багшлах аргазүйн шинэчлэл” төслийн эхний шат (2006-2009) болох “Суралцагчдын суралцахуйг дэмжих аргазүйн хөгжил” төслийн хүрээнд “Хүн байгаль” хичээлийн 3 зөвлөмж болон сурагчийн гарын авлагыг бэлтгэсэн.

1-р зөвлөмжийг ЕБС-ийн 7-р ангид “Бид ба ус” бүлэг сэдвээр нийт 17 цагийн хичээлийг бэлдэж туршсан бол 2-р зөвлөмжөөр “Би ба агаар” бүлэг сэдвээр нийт 10 цагийг 4-р ангид туршин хүүхдийн бие даах үйл болон өөрийгөө бусдад илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд анхаарсан. 3-р зөвлөмжид 5-р ангид “Агаар” бүлэг сэдвээр 10 цагийн хичээлийн хөтөлбөр боловсруулж, суралцагчдын багаар ажиллах чадварыг дээшлүүлэх бие даан бүтээлчээр ажиллах дасгал даалгавар туршилтуудыг оруулсан. 2009 оноос эхэлсэн “Багшлахуйн аргазүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх“ төслийн хоёрдугаар шатанд Японы багш нарын аливаа хичээлийг сайтар, ул үндэстэй судалж ажлын байран дээрээ багшлах аргазүйгээ дээшлүүлдэг “хичээлийн судалгаа”-ны аргын гол үзэл санааг “хүн байгаль” хичээлээр дамжуулан “Хүн байгаль” хичээлийн модулийг бэлтгэсэн.




Сорил туршилтаар мэдлэг бүтээх аргазүй. Зөвлөмж I–III

СУДЛАГДАХУУНЫ БАГ
МХСН
№ 001
Web: http://mals.mn/

# Мэдээлэл зүйн баг

Багийн уриа: *БАГШ НАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ЧАНАРТАЙ СУРГАЛТЫН ТҮЛХҮҮР.*

*Түүхэн товчоо*

**2006 он**
"Мэдээлэл зүйн сургалт, судалгааны төв" байгуулагдсан.

**2007 он**
"Айн киррикюлим боловсруулах арга зүй" зөвлөмж I хэвлэгдэв.

**2008 он**
"Асуудал шийдвэрлэх замаар мэдээллийг мэдлэг болгон хувиргах арга зүй" зөвлөмж II хэвлэгдэв.

**2009 он**
"Хэрэглээнд суурилсан сургалт зохион байгуулах арга зүй" зөвлөмж III хэвлэгдэв.

**2010 он**
Багшлахуйн хөгжил /мэдээлэл зүйн модуль/ зөвлөмж хэвлэгдэв.
2006–2012: Цуврал сургалт зохион байгуулав.

### "МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ТӨВ"-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

- Мэдээлэл зүйн болон МХТ-ийн боловсролын онол, арга зүй
- Мэргэжил дээшлүүлэх цуврал сургалт
- Эрдэм шинжилгээ, судалгаа
- Сургалтын цахим хэрэглэгдэхүүний сан
- Гадаад, дотоод хамтын ажиллагаа.

Тус багийнхан хамтарсан илтгэл, өгүүлэл (дотоод 10, гадаад 3) хэлэлцүүлж, Мэдээлэл зүйн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг хот, орон нутгийн 500 багшид зохион байгуулж, олон улсын уралдаан (Шанхай, Бээжин)-д ЕБС-ийн 2 багшийг бэлтгэн амжилттай оролцуулсан.

*МАНАЙ БАГИЙНХАН:*

## БАГШАА ДУРСАХУЙ



Бидний багш Л.Чойжооваанчиг нь МУБИС-ийн БУ-ны хичээлийн арга зүйн төв байгуулахад манлайлан оролцож, "Хичээлийн судалгаа"-ны төслийг эхлүүлэх, хэрэгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан АНХДАГЧ байлаа.

## Ф.ШИНОХАРА БАГШИЙН ЗӨВЛӨГӨӨ:



1. Аливаа судалгааны зорилго, үндэслэл тодорхой байх;
2. Хүрээлэн байгаа орчны бодит жишээг авч үзэх;
3. Мэдээлэл зүй нь бусад шинжлэх ухааныг судлах хэрэгсэл байх гэдэгт анхаарах.

*БИДНИЙ ТУРШЛАГА, ҮР ДҮН:*

- Судалгаанд суурилсан шинэ арга зүйн зөвлөмж
- Монгол болон Японы мэдээлэл зүйн багш нарын харилцан туршлага солилцох, хамтарсан сургалт, судалгаа хийх зэрэг олон бүтээлч үйл ажиллагаа
- Хичээлийн судалгааны арга зүйг багш бэлтгэх сургуулийн мэргэжлийн дидактик хичээл, багшлах дадлагад тусган хэрэгжүүлж байгаа.
- МХХТ-д суурилсан сургалтын арга зүйг дэмжих чиглэлээр бүх мэргэжлийн багш нартай хамтран ажиллаж байгаа.

*МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН БАГИЙН ЗАРИМ ГИШҮҮД*



# Химийн судлагдахууны баг



**"Нүхт"-д 2008 оны 9 сарын 11–13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан сургалтын үеэр. Зүүн гар талаас: Ц.Отгонбаяр, Г.Тамир, С.Хишигмаа, Н.Сүхбат, Б.Хандам, С.Баянзул, Ш.Цэгмэдсүрэн, Х.Баясгалан, Т.Дашдулам, Д.Оюунцэцэг, П.Лхагвасүрэн, А.Нямхүү, Ч.Нямгэрэл, Ш.Сайнбилэг**

БСШУЯ, ЖАЙКА-гийн хамтран хэрэгжүүлсэн хоёр шаттай төслийн хүрээнд ажилласан судлагдахууны 8 багийн нэг, төслийн манлайлагч хамт олон байж чадсан Химийн судлагдахууны багт МУИС, МУБИС болон ЕБС-иудын химийн 30 гаруй багш нар гар нийлэн хамтран ажилласан.

Химийн судлагдахууны баг (одоогийн харьяаллаар)-ийн ахлагчаар Ч.Нямгэрэл (МУИС), гишүүдээр: Н.Оюунцэцэг (МУИС), Г.Баярмаа (МУБИС), З.Урансайхан (Орчлон сургууль), Ш.Сайнбилэг (МУИС), П.Лхагвасүрэн (Хобби сургууль), Ц.Отгонбаяр (БХ), Ц.Лхамсүрэн (Шинэ Эрин сургууль), Ж.Энэбиш (БМДИ), Ж.Батбилэг (НБСГ), Туршилт хичээл заах багш (төслийн үеийн харъяаллаар)-аар А.Нямхүү (45-р сургууль), С.Оюунчимэг (Сэтгэмж ЦС), Д.Оюунцэцэг (Сэтгэмж ЦС), Т.Дашдулам (97-р сургууль), Н.Сүхбат (Сэлэнгэ, 1-р сургууль), Г.Тамир (Сэлэнгэ, 4-р сургууль), С.Хишигмаа (Сэлэнгэ, Хушаат), Б.Хандам (Дорнод, 5-р сургууль), С.Баянзул (Дорнод, Хан-Уул ЦС), Ш.Цэгмэдсүрэн (Дорнод, Матад), 2-р шатны төслөөс эхлэн хамтран ажилласан А.Дэмбэрэлнямбуу (Завхан, Чандмань-Эрдэнэ ЦС), Ц.Чимэдрэгзэн (Завхан, Чандмань-Эрдэнэ ЦС), Г.Дэмбэрэлмаа (Завхан, Чандмань-Эрдэнэ ЦС), М.Лхагвасүрэн (Завхан, 3-р сургууль), Б.Нэргүй (Завхан, Тэлмэн), Э.Сайнжаргал (Завхан, Завханмандал), Д.Балганцэрэн (Завхан, Сонгино) нар тус тус ажилласан юм. Хэдийгээр удирдлага, менежментийн багт хамаарч байсан ч яг л Химийн судлагдахууны багийн гишүүн шиг "химиэ" гэсэн сэтгэлээр ажилласан Х.Баясгалан (Дорнод, БСГ), Я.Нарангэрэл (Завхан, БСГ), Л.Сувдаа (Сэлэнгэ, БСГ) нартаа талархал илэрхийлье.

Химийн судлагдахууны багийн хамт олон төслийн хүрээнд Зөвлөмж 1: "Ус уусмал" сэдвийн жишээн дээр сорил тооцоогоор мэдлэг бүтээлгэх арга зүй (2007), Зөвлөмж 2: "Ус уусмал" сэдвийн жишээн дээр мэдээлэл боловсруулж мэдлэг бүтээлгэх арга зүй (2008), Зөвлөмж 3: "Нүүрстөрөгчийн шинж чанар-хэрэглээ" сэдвийн жишээн дээр контекстэд суурилан мэдлэг бүтээлгэх арга зүй (2009), Багшлахуйн хөгжил: Химийн хичээлийн модуль (2013) зэрэг гарын авлага материалыг боловсруулан хэвлүүлсэн.

## "ТӨСӨЛТ АЖИЛ" БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

2004-2005 оны хичээлийн жилээс ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд "Төсөлт ажил" хичээлийг оруулж, бага, дунд ангийн сургалтад нэвтрүүлсэн тэр цаг үеэс "Төсөлт ажил" баг бүрдэж, төсөлт ажлын онол, арга зүйн чиглэлээр судалгаа хийсэн болно.

Багийн ахлагч: Ц.Наранцэцэг /МУБИС-ийн Багшийн сургуулийн багш, ББДССТ-ийн эрхлэгч/ Багийн гишүүд: Б.Булган /МУБИС-ийн Багшийн сургуулийн ХА-ны дарга, доктор/, Ц.Оюун /МУБИС-ийн НХУС-ийн багш, доктор, проф/, Наканиши Рейко /УБ хотын "Эрдмийн ундраа" цогцолбор сургуулийн багш/, Зөвлөхүүд: Асанума Шигэрү /Токио Гакүгэй Их сургуулийн проф/, Тода Такако /Токио Гакүгэй Их сургуулийн проф/ нар байв.



Монгол Улсын БСШУЯ болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-ын хамтарсан "Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил" төслийн хүрээнд төсөлт ажлын арга зүйг монголын сургууль, багш, сурагчдын онцлогт тохируулан боловсруулж, түүнийг УБ хотын 45, 97, Сэтгэмж цогцолбор сургууль болон Дорнод аймгийн 5, "Хан-Уул" цогцолбор сургууль, Матад сумын сургууль, Сэлэнгэ аймгийн 1, 4, Хушаат сумын сургуулиудын багш нар туршсан.

Багш нар туршилт хичээлээрээ өөрийн гэсэн өвөрмөц өнгө аястай арга зүйг бүтээсэн юм. Тухайлбал, хүүхдийн судалгаа, судалгааны янз бүрийн шинжүүрт суурилсан арга зүйг бүтээсэн УБ хотын "Сэтгэмж" цогцолбор сургуулийн багш Д.Энхтуяа, сурагчдын судалгааны тэмдэглэл, сэтгэгдэлд түшиглэсэн арга зүйг бүтээсэн УБ хотын 97-р сургуулийн багш Т.Эрдэнэчимэг, төсөлт ажлын өвөрмөц орчинг бүрдүүлж, "орчин-өдөөгч, чиглүүлэгч байх" зарчим баримталсан арга зүйг бүтээсэн УБ хотын 45-р сургуулийн багш Ц.Оюунсанаа нарыг дурдаж болно. Энэхүү туршилтынхаа үр дүнгээр багаараа хамтран Төсөлт ажлын арга зүй I, III, III, Багшлахуйн хөгжил /Төсөлт ажил/ гэсэн нийт 40 гаруй хэвлэлийн хуудас зөвлөмжүүд боловсруулан хэвлүүлж, багш нарын хүртээл болгожээ.

# БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА



Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 180 дугаар тогтоолын дагуу Багшийн мэргэжил дээшлүүлэх институт гуравдахь удаагаа дахин бие даасан институт болж байгуулагдан үйл ажиллагаагаа зохион байгуулж байна. Энэхүү тогтоолоор батлагдсан "БМДИ-ийн дүрэм"-д "Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг боловсролын хөгжлийн бодлого болон нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан, орчин үеийн мэдээлэл харилцааны технологид суурилж, олон улсын стандартад нийцүүлэн зохион байгуулж, багшаар дамжуулан боловсролын салбарыг хөгжүүлэх" гэсэн эрхэм зорилготой ажиллаж байна.

ТОДРУУЛБАЛ:

◆ СӨБ, ЕБС-д эхний болон тав, арав дахь жилдээ ажиллаж буй 24,581 багш, удирдах ажилтанд мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт зохион байгуулж мэргэжлийн тасралтгүй хөгжил, ажлын байрны үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, бие даан болон хамтран хөгжих арга зүйн дэмжлэгийг мэргэжлийн байгууллагуудтайгаа хамтран үзүүлж байна.

◆ СӨБ, бага дунд боловсролын сургалтын байгууллагын багш удирдах ажилтнуудад боловсролын бодлого шийдвэрийг танилцуулах, хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой төрөлжсөн сургалтуудад 72,503 багш, удирдах ажилтан хамрагдаад байна. Боловсролын байгууллагад ажиллагсдын ажлын байрандаа мэргэжил дээшлүүлэх хүсэлт, хэрэгцээнд үндэслэн захиалгат сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, 7,177 багш ажилтанд арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.

◆ Гадаад харилцаа хамтын ажиллагааны чиглэлээр APCEIU (Ази, Номхон далайн ойлголцлын боловсролын олон улсын төв), JICA Олон улсын байгууллага, ОХУ-ын Зүүн Сибирийн улсын боловсролын академи, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын хүн амын сан, Азийн хөгжлийн банк, ОУ-ын монгол дахь төсөл хөтөлбөрүүдтэй хамтран сургалт, судалгааны ажлуудыг зохион байгуулах талаар тодорхой хэмжээнд туршлагажиж байна.

◆ Мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаанд мэдээлэл харилцааны технологийг нэвтрүүлэх, багш бүрт ажлын байрандаа хамтран хөгжих нээлттэй адил, тэгш боломж бүрдүүлэх зорилгоор 2014 оноос үндсэн сургалтын бүтцэд онлайн хэсэг оруулан хэрэгжүүлж эхэлсэн нь манай байгууллагын инновацийн гол чиглэл болж байна.

◆ ТХБ-ыг иргэд олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, тэр дундаа ЕБС-ийн хөтөлбөрөөр дамжуулан ТХБ-ыг олгох зорилгоор монгол дахь "Тогтвортой хөгжлийн боловсрол" төсөл, БОМСТ-тэй хамтран дотоодын хүний нөөцийг чадавхжуулах шаталсан сургалтууд, ЕБС-ийн багш нарт "Сургалтын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй-тогтвортой хөгжил-хүүхдийн хөгжил" сэдэвт сургалтуудыг үе шаттай зохион байгуулж ирлээ.

БМДИ нь 3 дахь удаагаа дахин байгуулагдсан хугацаанаас хойш буюу 2012-2018 онд байгууллагын үндсэн чиг үүрэг, боловсролын салбарын хууль, дүрэм, журмын хүрээнд багшийн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг боловсролын байгууллагын ажилтан, албан хаагчдын мэргэжлийн хөгжлийн хэрэгцээнд үндэслэн, олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулж байна.

Тус институтийн арга зүйчид өмнө нь ЕБС, цэцэрлэгийн багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт зохион байгуулж, хичээл заахад голлон анхаарч ирсэн бол шинэ бүтцээр ажиллахад дараах өөрчлөлт орж, чиг үүрэг илүү өргөжиж байна.

**Үүнд:**

◆ Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэсэн сургалт болон олон талт үйл ажиллагааг холбогдох төрийн захиргааны төв болон мэргэжил аргазүйн сургалт явуулах чиг үүрэг бүхий үндэсний хийгээд орон нутгийн байгууллагуудын чиг үүрэгт тусган хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж ажиллах

◆ Судалгаанд суурилсан сургалт-хөгжлийн ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох, эрдэм шинжилгээ, онол практикийн хурлын хүрээг тэлэх, чанаржуулах, багш бэлтгэх их дээд сургуулийн болон ЕБС-ийн багш нартай хамтын судалгаа туршилт хийх

◆ Арга зүйчдийн хариуцан ажиллах зорилтот бүлгийн хүрээ Насан туршийн боловсролын төв, МСҮТ-ийн ерөнхий эрдмийн сургуулийн багш нарын мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэхээр өргөжих

◆ Арга зүйчдийн ажлын чиг үүрэг өөрчлөгдөж, зорилтот бүлгийн мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх сургалт, үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах менежерийн үүргийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх

◆ Арга зүйчдийн өөрсдөө хичээл заахын зэрэгцээ мэргэших, өндөр чадамжтай мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг гүнзгийрэх

◆ Бүх шатны боловсролын байгуулагын багшийн хөгжлийн төвийг багш нарын бие дааж мэргэжил, мэдлэгээ тасралтгүй дээшлүүлэх, хөгжих нөхцөлөөр ханган шаардагдах мэргэжил арга зүйн дэмжлэгийг үзүүлэх

◆ Багшийн хөгжилтэй холбоотой судалгаанд суурилсан мэдээллийг олон нийтэд хүргэж, мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг дэмжин ажиллах

◆ ЕБС, цэцэрлэгт эхний болон 5,10 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын агуулгыг тэдний ялгаатай хэрэгцээнд үндэслэн хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх

◆ Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, гэр бүл, байгууллага, олон нийттэй хамтран ажиллах, тэдний оролцоог хангах

◆ Хүүхэд судлал, хүүхэд хөгжил, хүүхэд хамгаалал, суралцахуйн хөгжлийн чиглэлээр сургалт, судалгааны ажил хийх, гарын авлага зөвлөмж боловсруулах гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа зохион байгуулах шинэ хэрэгцээ шаардлага үүсэж байна.

# ӨӨРИЙН УДИРДЛАГАТАЙ ТАСРАЛТГҮЙ, ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД БАГШ ХӨГЖИНӨ

***БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН ДЭД ЗАХИРАЛ О.ОЮУНТУНГАЛАГ***



**-Жайкагаас хэрэгжүүлсэн төслийн үр дүнг БМДИ /Багшийн мэргэжил дээшлүүлэх институт/ албан ёсоор өвлөж үлдсэн үү?**

-БШУСЯ, Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ЖАЙКА)-тэй хамтран 2006-2013 онуудад "Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил", "Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх нь" төслийг хоёр үе шаттай хэрэгжүүлсэн билээ. Эдгээр төслүүдийн үр дүнг тогтвортой үргэлжлүүлэх, гадаад, дотоодын зөвлөхүүд болон багш нарын боловсруулсан арга зүй, технологи, багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх, хичээлийн судалгааг тогтвортой үргэлжлүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон. Энэ цаг үед БМДИ шинээр байгуулагдаж, БСШУСЯ-ны удирдлага дор мэргэжлийн багуудтай хамтран хичээлийн судалгааны арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээсэн. Бид БСШУСЯ-тай хамтран үндэсний хэмжээнд 2013-2018 онд "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх" үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж үр дүнг тооцон ажиллаж байна.

**-Багш нарын мэргэжлийг тав таван жилээр дээшлүүлнэ гэсэн хуулийн заалт байдаг байхаа?**

-Боловсролын тухай хуулинд "ЕБС, СӨБ-ын багшийн мэргэжлийг өмчийн хэлбэр үл харгалзан улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутам дээшлүүлнэ" гэсэн заалт бий. Энэхүү заалтын хүрээнд 1,5,10 жил ажиллаж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг зохион байгуулж байна. Үндсэн сургалтын хөтөлбөрт хичээлийн судалгааны тухай, арга зүй, үе шат, хэрэгжүүлэх менежментийг ойлгуулах, ялангуяа залуу багш нар хичээлийн судалгааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ажлын байрандаа хэрэгжүүлэх, багшийг хөгжих хөшүүрэг болгон үндсэн сургалтын үргэлжлэл болсон онлайн сургалтын даалгаврын агуулгад оруулж туршиж, хэрэгжүүлж, үр дүнг тооцохоор хичээж байна.

**-Хичээлийн судалгаа багшийн заах арга зүйд багагүй нөлөөтэй биз?**

-Багшийн мэдлэг, ур чадвар зөвхөн танхимд авчирч сургалт хийснээр сайжрахгүй. Багшийн чин хүсэл, зүтгэл, санаачлага, өөрийгөө хөгжүүлэх өөрийн удирдлагатай тасралтгүй, хамтын үйл ажиллагааны үр дүнгээр хүүхдийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангана гэж би боддог. Багшийн тасралтгүй хамтын ажиллагааны нэг хэлбэр бол хичээлийн судалгаа, багш нарын заах арга, ур чадварт ахиц гарч байгаа ч анхаарах асуудлууд, шийдвэрлэх арга замыг хэлэлцэх хэрэгцээ шаардлага ч гарч байна. Энэхүү хэрэгцээ шаардлагын хүрээнд Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгтэй хамтран энэ асуудлыг шийдвэрлэх, хичээлийн судалгааны менежментийг сайжруулах ажлыг хамтарч хийж эхэлсэн. Энэ зорилгоор жил бүр, хүүхдийн хөгжлийг дэмжсэн арга зүй, технологийн нэг - хичээлийн судалгааны менежмент, төрөл, арга хэлбэрийг өөрийн багшлах үл ажиллагаа, сургуульд хэрэгжүүлсэн арга туршлага, үр дүн, ололт амжилт, шийдлийн талаар хэлэлцэж туршлага солилцох зорилгоор МХСН-тай хамтран жил бүр ЭШХ /онол практикийн бага хурал/ зохион байгуулж байна. Энэ үйл ажиллагаанд оролцож, үр нөлөөтэй илтгэл тавьж хэлэлцүүлсэн багш нараа Япон, Солонгос, ОХУ руу сургалт- туршлага судлуулахаар явуулдаг нь багш нар нүд тайлах, арга туршлагаа баяжуулах, бусаддаа дэлгэрүүлэх ач холбогдолтой юм. Энэ жил 6 дахь хурлаа зохион байгуулах бэлтгэлээ хийж байна. Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг, цаашлаад Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэг тусламжтайгаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр шим монголын хөрсөнд бууж үр дүнгээ өгч байгаад институтийн хамт олны зүгээс талархалтай байдгийг онцлон хэлмээр байна.

**-Цаашид МХСН-тэй хамтран голлон анхааран ажиллах чиглэл юу байна?**

-Цаашид эрдэм шинжилгээний хурлын хүрээг тэлэх, чанаржуулах, багш бэлтгэх их дээд сургуулийн болон ЕБС-ийн багш нартай хамтын судалгаа туршилт хийх, БМДИ-ээс эрхлэн гаргадаг "Багшийн хөгжил" сэтгүүлд хичээлийн судалгааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөмж арга зүйн булантай болох, шинэ судлагдахуунуудад хичээлийн судалгааг хэрэгжүүлэхэд зориулсан гарын авлага гаргах, хичээлийн судалгааг хэрэгжүүлж буй тэргүүн туршлага,арга зүй технологийн сан бүрдүүлэх, нийтийн хүртээл болгох, "сургуульд суурилсан хичээлийн судалгааны шинэ менежмент"-ийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, мониторинг хийх, зөвлөн туслах, орон нутгийн хэмжээнд хүний нөөцийг бэлтгэх, бүтэц зохион байгуулалтыг сайжруулах зэрэг хэрэгцээ шаардлага шинэ шатанд үүсэж байна. Үүний төлөө хөгжлийн дараагийн шатны ажлуудыг хийхээр зорьж байна. Ингээд МХСН-ий үүсгэн байгуулагчид, хамт олон, удирдах зөвлөлийн гишүүд, шинжээч, сургагч багш нартаа монголын багш нарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаад дахин талархал илэрхийлж сайн сайхныг хүсэн ерөөе.

# LESSON STUDY

MXCH



AKITERU FUKUCHI

*Professor emeritus, Tokyo Gakugei University, Representative Director, "Minato Lesson Training Academy" (Nonprofit Organization)*

## CONGRATULATION ON 5TH ANNIVERSARY OF MONGOLIAN ASSOCIATION OF LESSON STUDIES

JICA "Teaching Methods Improvement Project towards Children's Development" (the Project Phase 1) started in 2006 to respond to strong needs of Mongolian education sector that experienced a transition from "teacher centered teaching methods" to "child centered lessons". The Project was implemented in cooperation with Teaching Methods Improvement Centers established in National University of Mongolia and State University of Education and Japanese expert team (KRI International Corp. and Tokyo Gakugei University). "Lesson Study", "KYOZAI KENKYU (Teaching Material Study)", and "Child development" were selected as keywords of the Project Phase 1 for 3 years and "Lesson Study" which has been improving teaching methods in Japan contributed to the success of the Phase 2 (JICA Project for Strengthening Systems for Improving and Disseminating Child-Centered Teaching Methods in Mongolia). I am deeply impressed that it is now succeeded to Mongolian Association of Lesson Studies.

I believe that teachers' willingness to improve their lessons has the biggest impact on students' learning achievement. As a coordinator of training in Japan, I delivered my message to Mongolian teachers through hands-on experience at school. Through observation, teaching material and lesson composition were well understood by the teachers. Ownership of Working Groups to develop the 3rd teachers' guidebooks changed the project dramatically. Model Schools conducted "Lesson Study" to examine the effectiveness of the teachers' guidebooks that became a foundation to disseminate "child centered teaching method." I clearly remember seminars conducted in Ulaanbaatar and discussion with "Human and Environment", "Human and Nature" and "Integrated Studies" Working Groups. I will never forget our field trips; though our arrival was delayed because of accident, students presented us their beautiful dance and songs in Zavkhan. Every time we visited, teachers in Selenge and Dornod gave us warm welcome.

"Human and Environment" composed of Living Environment Studies and Science is my major. Development of local teaching material was a crucial point of this subject. "Human and Nature" Working Group selected "water" and "air" as topics and developed "Context-based" teaching material and experimental methods. and I learned about Mongolian culture and history through "Integrated Studies" covering many fields from primary to secondary education.

Mongolian Association of Lesson Studies started Study Tour in Japan. I always considered how we can make a-week-tour fruitful to meet needs of participants who have various backgrounds such as evaluation, teacher training, and pre-school education.

Tours focusing on "Lesson Study" and "KYOZAI KENKYU" were conducted, thanks to the following organizations; Board of Education in Minato District, "Minato Lesson Training Academy", Seinan Elementary School, Onarimon Elementary School, Aoyama Junior High School, Konan Junior High School, Shirogane-no-oka Gakuen (elementary and junior high school), Seinan Kindergarten, Konan Kindergarten, Setagaya Elementary School and Junior High School attached to Tokyo Gakugei University.

The participants learned many things through observation; school-based lesson study of Integrated Studies and Science, group lesson of mathematics, resource room for special needs education (language and hearing class), school practices to enhance students' self-esteem, swimming lesson, ICT equipment, and school lunch as dietary education. "Activities of Minato Lesson Training Academy" showed that connection between education and local community is quite important for child development.

We heard that the participants shared their experiences in Japan with others during a report seminar. We really hope that they keep contributing to education in Mongolia by utilizing their knowledge and skills obtained in Japan.

*I wish you many more successful years.*



*Shu MATSUURA*

*Setagaya Elementary School attached to Tokyo Gakugei University*

## STUDY TOURS FROM MONGOLIA VISIT OUR SCHOOL EVERY YEAR

Honored to express congratulation to the 5th anniversary of the Mongolian Association of Lesson Studies.

As a member of Physics and IT Education Expert for JICA "Project for Strengthening Systems for Improving and Disseminating Child-Centered Teaching Methods in Mongolia" from 2010 to 2013, I attended Lesson Study seminars in Ulaanbaatar, Zavkhan, Bulgan, Bayan-Ulgii, Selenge, and Umunugovi. Schools in the countryside warmly welcomed and kindly accommodated us at their dormitories. I would like to express my gratitude and appreciation to those who accepted us.

Though Mongolia has a vast land area, I noticed that people speak the Mongolian language with a similar intonation, that is very different from Japan which has many local dialects. However, it is as well convincing if I consider that the Mongolian people established the largest ever empire on the earth in the 13th century.

When we landed at an airport by a propeller plane, I was astonished noticing that I was surrounded by crystal clear air, dry white snow mountains, and quietness without reverberant sounds. Late at night, the students welcomed us with various cultural presentations with colorful feathery costumes despite the freezing air. While taking a picture with a cute child performer, I realized a gentle smile of her grandparents.

When I visited Mongolia during winter, I usually wore mountain climbing boots. Once I borrowed overshoes with fur, it made my legs warm in a cold Russian car called "purgon – UAZ452". I understood why wildlife can survive through the freezing winters and why Mongolian people can enjoy their life in the harsh natural environment.

After the lesson observations and discussion, it usually came time for singing and dancing. This is very different from the Japanese one. (We typically chat after the seminar.) Drinks, synthesizer, songs, social dances, and disco dance. MCs usually looked so neat. I could not master the social dances, but I enjoy these night times.

A principal who accommodated us in Zavkhan taught me that students must master three things; playing chess, Morinkuur, and IT, that is equivalent to the ability to think, the traditional culture and skill to access future, respectively. It is a wonderful idea.

At the same time as the establishment of Mongolian Association of Lesson Studies, I was assigned as a principal of Setagaya Elementary School attached to Tokyo Gakugei University. Five years have passed. Study tours from Mongolia visit our school every year. I hope our good relationship will continue.

**Congratulations on the fifth anniversary of Mongolian Association of Lesson Studies!**

# THEY REMINDED ME OF MANY HAPPY DAYS

Masahiro KAMATA

*Science Education, Tokyo Gakugei University, Japan*



I am truly happy to know that you have created and managed a viable organization over five years which is beneficial to all the teachers in Mongolia.

When I visited Mongolia for the first time in 2006, I used to be asked to teach the best teaching method for Mongolian teachers. Whenever this request came, I answered "You have to find the best method by yourselves. Although I can inform you a lot about Japanese methods to you, it is you that should develop the best method for you and spread it to all teachers in Mongolia." When I left Mongolia in 2013, I was not sure if you could find the best for you. But now, I am sure you did, and you are now doing it.

Before I wrote this document, I searched for my old pictures I took in Mongolia. They reminded me of many happy days I spent with you and your students. My favorite one (see below) was a picture of the students who were engaged in science craft happily. Since science craft is my specialty, I often use this picture in my lectures to illustrate that children like making craft not only in Japan but also in many countries. One of the new crafts I recently created was based on my experience in Mongolia as shown in next picture. This means that we can share our ideas and learn more from each other to develop teaching methods in both countries

Finally, I sincerely would like to express my best wishes to you for the further development of Mongolian Association of Lesson Studies.



*Kamara's recent work (Hand-drawn resistors) https://sites.google.com/site/kamatalabnew/r13e*

# I wish you continued SUCCESS and HEALTH

Hiroshi TAKAHATA

*Professor emeritus, Tokyo Gakugei University*



***12 years have passed since JICA "Teaching Methods Improvement Project towards Children's Development" (the Project Phase 1) was started in 2006.***

12 years have passed since JICA "Teaching Methods Improvement Project towards Children's Development" (the Project Phase 1) was started in 2006. The project was composed of Phase 1 and Phase 2 (JICA Project for Strengthening Systems for Improving and Disseminating Child-Centered Teaching Methods in Mongolia) and totally for 7 years, that is equivalent to 17% of my working life at university. I would like to write about my best memory of the projects here, however I have too many beautiful memories to pick up one or two of those. When I hear "Mongolia", I vividly recall Giant Turtle Rock in Terelji, clear streams, straight roads in snow fields, star-filled sky, UB town with snow which was a view from a hotel window. I also remember Professional Team members, interpreters, and drivers who traveled around in country side for monitoring. 17 % of my working life at university was precious time.

I sometimes look back over the projects and wonder if we could contribute to education in Mongolia. When I visited Mongolia for the first time, Mongolian teachers were given new education standards, and were required to shift from "teacher centered lessons" to "child centered lessons". Since the teachers attended "teacher centered lessons" throughout their school days, they did not know how to conduct "child centered lessons". We were expected to deliver "child centered lessons" from Japan as an advanced country of teaching methods. In fact, lessons which we observed at several schools were "teacher centered lessons". Gradually, we learned that not only teacher's learning experience but also contents of textbooks and traditional education system had negative impacts on teaching methods. Under such circumstances, I started to wonder if "transplant" of Japanese teaching methods to Mongolia was meaningful or not.

We tried to "transplant" Japanese teaching methods to Mongolia as Mongolian counterparts wished. The training in Japan was also designed to realize their wish and "Lesson Study" was introduced as a tool. However, we noticed that it was not a good solution and we should support in a sustainable way, like "teaching cultivation and providing seeds instead of giving wheat". It looked an indirect way however, it helped a bright future of Mongolian education.

No more hesitation among us.We provided "Lesson Study" as a method for teachers to develop themselves and trained trainers. When I left Mongolia in March 2013, I found signs of success. Of course, there were many difficulties in the process such as misunderstanding of "Lesson Study" as teacher evaluation and only positive comments during the discussion, those are sweet memories now.

5 years have passed since Mongolian Association of Lesson Studies was established. You may face challenges to continue your work sometimes however, I believe "Lesson Study" for students provides teachers with fulfilment. Soon, "child centered teaching method" will be developed in accordance with Mongolian context and disseminated to all over Mongolia.

*I wish you continued success and health.*



**Tetsuya ISHII**

*Founding Member, Mongolian Association of Lesson Studies*
*Executive Officer, Koei Research & Consulting, Japan*
*1.Project for Teaching Method Improvement Towards Children's Development in Mongolia (May 2006 to July 2009)*

# LSA PROJECTS WHICH LED TO ESTABLISHMENT OF MONGOLIAN ASSOCIATION OF LESSON STUDY

With reform of the education sector, new education standards were introduced in September 2005. Teachers were expected to change from conventional method of teaching that emphasized memorization to the method that encouraged children's imagination and ideas, such as "teaching methods which support children's development". However, teachers of that time were trained in conventional methods of teaching based on memorization, thus did not understand the teaching method which support children's development. Also the contents of the standards are rather academic for school teachers. They had faced difficulties in practicing the new teaching method prescribed in the standards.

Under such circumstances, the Ministry of Education, Culture and Science decided to implement the Project for Teaching Methods Improvement Towards Children's Development in collaboration with JICA in May 2006.

| Ulaanbaatar City | Selenge Aimag | Dornod Aimag |
|---|---|---|
| School No.45<br>School No. 97<br>Setgemj<br>Complex School | School No.1<br>School No.4<br>Khushaat Soum School<br>Gurvanbulag Soum School<br>Kutag-Undur Soum School | School No.5<br>Khan-uul Complex School<br>Matad Soum School |

*Three schools from each Aimag/City were selected as the Project's model schools.*

The teaching methods that are intended to realize the idea of the new education standards, were developed by the four Teaching Methods Improvement Centers in Mongolia through developing 8 teachers' guidebooks (Physics, Chemistry, Primary Science, Human and Nature, Primary Mathematics, Secondary Mathematics, Integrated Studies, and IT).

In those model schools, trial lesson using the draft teachers' guidebooks were conducted. Through these trial lessons, the teachers' guidebooks were improved. In addition to the various training/workshops conducted in Mongolia, 18 people were sent to Japan to learn teaching methods in Japan.

Teachers' Guidebooks (I. II. III) for 8 subjects, Monitoring Manual, and Teachers' Guidebook Development Manual were as the outputs of the Project.

2. Project for Strengthening Systems for Improving and Disseminating Child-Centered Teaching Methods (April 2010 to August 2013)

As a follow-up to Mongolia's education reform, it was considered necessary to disseminate the teaching methods which were developed during the previous project. which was implemented since 2010, aims capacity development of teachers as well as Department of Education and Culture of each Aimag to practise and disseminate the new teaching method properly.

The Training Package consisted of 8 modules for teachers, module for school administrators, and management modules were developed.

In developing the training package, subject-wise Professional Teams were developed. The Professional Team members conducted various training for teachers of the model schools. The Professional Team members were designated by the MES Minister's Order No. 575 of 2010 and No. 428 of 2011.

The Institute of Teachers' Professional Development (ITPD) which was re-established in 2012 had significant impact on training of teachers and dissemination of lesson study. The ITPD collaborated with the project activities in various ways. Specialists of ITPD participated in training and monitoring activities. In the ITPD's national training program for teachers with 5-year experience, the lesson study was introduced. At the end of the project, the ITPD issues a "List of Lesson Study Experts, Advisors and Teachers" together with the JICA Project Team.

The training and monitoring for teaching method improvement utilizing Lesson Study was not only conducted in the above model district and Aimags. The Project's training and monitoring activities involved 17 Aimags.The training in Japan was conducted in 4 batches and 71 people participated in the training.

| Songino Khairkhan District | Bulgan Aimag | Zavkhan Aimag |
|---|---|---|
| Ireedui Complex School<br>School No. 12<br>School No.67 | School No.1<br>Khisig-Undur Soum School<br>Selenge Soum School<br>Gurvanbulag Soum School<br>Kutag-Undur Soum School | Chandman-Erdene Complex School<br>Shiluustei Soum School<br>Songino Soum School<br>Bayantes Soum School<br>Tosontsengel Soum School<br>Zavkhan Mandal Soum School |

*14 schools from Songino Khairkhan of Ulaanbaatar, Bulgan Aimag, and Zavkhan Aimag were designated as the project's model schools.*

International Activities

Mongolian teachers started its international learning and exchange program during this period.

The Project also conducted the technical exchange program with Indonesia. 10 people attended the technical exchange program in Indonesia.

1 Faculty member of the National University of Mongolia attended the World Conference of World Association of Lesson Studies (WALS) in Singapore in 2012. The following year, 2 presentations were made in the WALS conference in Sweden, - one from Institute of Teachers' Professional Development, and one from JICA Project Team. Since then, Mongolian teachers participate the WALS Conference every year. Study tours to Japan have been organized by MALS since 2014.

I wish all the success for Mongolian teachers, and happiness for Mongolian children.

# I REMEMBER IT AS IF IT HAD HAPPENED JUST YESTERDAY



**Sayaka SUZUKI**

*Founding Member, Mongolian Association of Lesson Studies*
*Senior Consultant, Koei Research & Consulting*

*On August 16, 2013, establishment of "Mongolian Association of Lesson Studies" was proposed during the first Lesson Study Conference in Ulaanbaatar and agreed by all participants with a big round of applause. I remember it as if it had happened just yesterday.*

To celebrate the 5th anniversary of Mongolian Association of Lesson Studies, I would like to write about the Project activities just before its establishment, that is just before the termination of JICA "Project for Strengthening Systems for Improving and Disseminating Child-Centered Teaching Methods in Mongolia" (the Phase 2 Project) in 2013.

During the JICA "Teaching Methods Improvement Project towards Children's Development" (the Project Phase 1), the Project Team and Mongolian counterparts discussed what was "child-centered teaching method" and made it into practice by "Lesson Study". The Project Phase 2 focused on teacher training by "School-based Lesson Study" and its institutionalization. At the last of 7 years project, the Project created following opportunities for teachers who were pursuing child-centered teaching method to upgrade teachers' professionalism.

**■ CONDUCTED PRIMARY MATHEMATICS SEMINAR:**

In collaboration with the JICA Volunteers, primary mathematics seminars were conducted once a month for six months (from January to June 2013). Different theme was set for each seminar such as addition and subtraction of fraction, area of trapezoid, introduction of multiplication, etc.

**■ DISSEMINATED GOOD PRACTICES THROUGH "TEACHER NEWSPAPER":**

Posting of articles on "Teacher Newspaper" was made for 7 times from March to June 2013 in order to introduce good lesson practices based on "KYOZAI KENKYU (teaching material study)" of the Model Schools.

**■ CREATED OPPORTUNITIES OF PRESENTATION:**

The Project encouraged Mongolian counterparts to present results of their study. Two members of Professional Team participated in Japan Society for Science Education National Conference in August 2013 and the first Lesson Study Conference involving many teachers was organized in Ulaanbaatar in August 2013.

A teachers' professionalism is not fostered by conducting lessons simply following textbooks or teachers' guidebooks, and also by compulsory teacher training. It requires teachers to deepen their knowledge and skills in his/her own initiative and continued "KYOZAI KENKYU" for many years. I highly recommend that research activities should be continued such as reviewing own practices, finding out issues, and learning from other teachers' practices.

**THE LAST ARTICLE OF "TEACHER NEWSPAPER" IN JUNE 2013, I WROTE AS BELOW:**

*"There are many small schools in country side which have only one teacher for each subject. Even if you study hard and develop new teaching contents and methods, no one may evaluate you from the professional point of view. However, students know how you put your mind to lessons. They may tell it to their parents. Another teacher in another soum school also studies very hard and conducts lessons for his/her students. You are not alone."*

I wish Mongolian Association of Lesson Studies always supports such teachers in difficult situation but devoting his/herself to students.



# БҮХ ДАВУУ ТАЛЫГ НЬ ГАРГАЖ ХӨГЖҮҮЛЭХ ЁСТОЙ

## МУИС-ИЙН ХИМИЙН ТЭНХИМИЙН ДЭД ПРОФЕССОР, ДОКТОР Ч.НЯМГЭРЭЛ

**-Хичээлийн судалгааны нийгэмлэг дэх Таны оролцоог дурдана уу?**

-2006-2013 онд Японы Олон улсын Жайка байгууллага Боловсролын яамны хамтран хэрэгжүүлсэн 2 шаттай төслийн үр дүнгийн тогтвортой байдлыг хангах буюу Хичээлийн судалгааг түгээн дэлгэрүүлэх хөгжүүлэх зорилгоор Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг байгуулагдсан. ЖАЙКА-ийн төслийн 2 шатанд миний бие химийн судлагдахууны багийг ахалж ажилласан бөгөөд Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг ТББ-ын үүсгэн байгуулагчдын нэг. Тус нийгэмлэгт химийн хичээлийн судалгааг хэрэгжүүлэх, судалгаагаар дамжуулаад химийн боловсрол судлалын чиглэлийн судалгааг хөгжүүлэхэд хамт олноо чиглүүлж ажилладаг. Химийн хичээлийн судалгааг хөгжүүлэх чиглэлээр арвин туршлага хуримтлуулсан, хамтарч ажилладаг олон багш нар бий.

**-Энэ чиглэлд Та хилийн чанадад анхны илтгэлийг тавьсан гэж сонссон?**

-2012 онд Сингапурт зохион байгуулагдсан Олон улсын хичээлийн судалгааны хурал миний удирдсан магистрын оюутан Ж.Энэбишийн Баянзүрх дүүрэгт хэрэгжүүлсэн хичээлийн судалгааны зарим үр дүнгээс илтгэсэн нь Монгол Улсаас хэлэлцүүлсэн анхны илтгэл болсон. Энэ хуралд оролцож илтгэл хэлэлцүүлэх боломжоор хангаж, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн МУИС-ийн ХХИС (хуучнаар)-ийн захиргаа, мөн ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газарт талархаж явдаг. ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролыг интеграцчлах тулгамдсан шинэ асуудлыг хичээлийн судалгаатай хэрхэн уялдуулах вэ гэдэг санааг дэвшүүлсэн, "Хичээлийн судалгаа ба тогтвортой хөгжлийн боловсрол" гэсэн илтгэлийг Н.Нэргүй багштай хамтран бэлтгэж "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй" сэдэвт онол, практикийн V бага хуралд үндсэн илтгэлээр хэлэлцүүлсэн. Мөн 2018 оны 9 дүгээр сарын 5-29-нд Японы Хирошима хот дахь Жайкагийн сургалтын төвд Хичээлийн судалгаагаар дамжуулж боловсролын чанарыг дээшлүүлэх нь гэсэн хичээлийн судалгаан дээр төвлөрдөг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаад ирсэн.

**-Хичээлийн судалгаа хаана анх үүссэн бэ?**

-Хичээлийн судалгаа анх Японд үүссэн. Түгжигдмэл арлын улс байгаад XIX зууны дунд үед баруун Европын орнуудын мэргэжилтнүүдийг урьж танхимийн сургалтыг анх Японд нэвтрүүлэх үеэр хичээлийн судалгаа хамт үүссэн гэж үздэг. 1990 оны эхэн үеэс Америкт доктор хамгаалсан японы математикч америк болон японы математикийн боловсролын харьцуулсан судалгааны хүрээнд Японд хийгддэг математикийн хичээлийн судалгааг авч үзсэн нь Хичээлийн судалгаа Японоос Америкт түгэн дэлгэрэх эхлэл болсон гэж эх сурвалжуудад бичсэн байдаг. Ийнхүү англи хэл дээр хичээлийн судалгааны талаар танилцуулагдаж улмаар дэлхийд түгсэн гэж үздэг. Хичээлийн судалгаа нь **нэгд**, багш ажлын байран дээрээ мэргэжлээ дээшлүүлэх тогтолцоо болдог, **хоёрт**, хичээлийн судалгаагаар дамжуулаад багшлах арга зүй хөгжиж байдаг, **гуравт**, хүүхэд яаж суралцдаг вэ гэх мэтээр дидактикийн олон судалгааг давхар хийх боломжтой байдаг зэрэг олон давуу талтай. Иймд Монгол Улсад хичээлийн судалгааг энэ бүх давуу талыг нь гаргаж хөгжүүлэх ёстой гэж үздэг.

# МОНГОЛЫН ОНЦЛОГТОЙ ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААГ ДЭЛХИЙД ТАНИУЛАХ ХҮСЭЛТЭЙ ЯВДАГ

***МУБИС-ийн Математик байгалийн ухааны сургуулийн хөтөлбөрийн албаны дарга, доктор Т.Ганбаатар***



**-Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгтэй Та хэрхэн холбогдов?**

-2006 оноос эхэлж хэрэгжсэн Жайкагийн хоёр шатлалтай төсөлд "Дунд ангийн математикийн баг"-ийн ахлагчаар ажилласан. Анх Япон руу сургалтад явсан 10 хүний бүрэлдэхүүнтэй багт багтсан. Тэндээс эхлэж оролцож эхэлсэн гэсэн үг. Уг төсөл 2013 онд дуусахад Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (МХСН) байгуулж, хичээлийн судалгааг тогтвортой авч явах санаачлагыг гаргасан хүмүүсийн нэг. Би МХСН-ийн Удирдах зөвлөлийн гишүүн, нийгэмлэгийн судалгааны хорооны ахлагчаар ажиллаж ирлээ. Нийгэмлэгийн үйл ажиллагаанд эхнээс нь оролцож МХСН-ийн зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, танилцуулга хийх зэрэгт Н.Оюунцэцэг, Ч.Нямгэрэл, Ганбат багш нартай хамт ажиллаж байлаа. Мөн Нийгэмлэгийн хэвлэл мэдээлэл, сурталчилгааны хэсгийг нэг хэсэг хариуцаж явсан. МХСН, БМДИ-ээс жил бүр хамтран зохион байгуулдаг ЭШХ-д эксперт, зөвлөхөөр ажиллаж, илтгэл хэлэлцүүлж хамтарч ажиллаж байна.

**-Хичээлийн судалгааны ач холбогдлыг цөөн үгээр хэлбэл...**

-МХСН-ийн онцлог бол хичээлийн судалгаанд оролцож байгаа бүхий л мэргэжлийн багш нарыг арга зүйгээр дэмждэг. Багш нар хамтраад хичээлийн судалгаа хийснээрээ багшийн ур чадвар, мэргэжлийн хөгжилд нөлөөлдөг. Энэ үүднээс хичээлийн судалгаанд оролцож буй бүх хүмүүсийн арга зүй, мэргэжил боловсролыг дээшлүүлэх, зааж буй хичээлд судалгааны үндсэн дээр хандах боломж бололцоог олгож байгаа юм. Би өөрөө ч гэсэн хичээлийн судалгааг 2006 оноос хийж, 2016 онд Боловсрол судлалын докторын зэргээ хичээлийн судалгааны чиглэлээр Монголд анх удаагаа хамгаалсан.

**-Хийгдэж буй зарим нэг ажлаас дурдана уу?**

-МХСН байгуулагдсанаас хойш орон нутгийн сургуулиудаас хамтарч ажиллая гэсэн санал санаачилгууд гаргаж байгаа. Бид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургуульд Нийгэмлэгээс 2 хүн очиж аймгийн хэмжээний хичээлийн судалгааны ерөнхий үндэслэл, арга зүйн практик сургалтыг зохион байгуулж ирсэн. Тэр сургалтын дараа тус сургууль аймгийн хэмжээнд хичээлийн судалгааг таниулсан үйл ажиллагаа явуулж байгаа. Хөвсгөл аймгаас сүүлийн жилүүдэд болж буй хичээлийн судалгааны хурлуудын илтгэлийн уралдаанд нэлээд багш нар дээгүүр байр эзэлж гадаадад сургалтаар явах эрх авсан. 2018 оны хавар Дорнод аймгийн төвийн болон зарим сумдын сургуулиуд багш нараа хамруулж МХСН-ийн экспертүүдээр хичээл заалгасан. Хичээлд яаж ажиглалт хийхэв, хэрхэн хэлэлцэх вэ гэдгийг бодит хичээл дээр хийж хэлэлцсэн нь илүү үр дүнтэй байлаа. Лекц байдлаар явж ирсэн сургалтыг сүүлийн үед илүү практиктай холбож явуулж байгаагаар онцлог байна.

**-Нийгэмлэгийн цаашдын хөгжлийн талаар...**

-Дэлхийн хичээлийн судалгааны нийгэмлэгийн жил бүрийн хурал Монголын төлөөлөл 2012 оноос хойш тасралтгүй оролцож байгаа. Монголын гэсэн онцлогтой хичээлийн судалгааны арга, аргачлалыг боловсруулах, МХСН иймэрхүү үйл ажиллагаа явуулдаг, хичээлийн судалгаа хэрэгжсэнээр багш нар ингэж хөгжиж байна гэдгийг олон улсын түвшинд гаргах талд анхаарч ажиллах хүсэлтэй байна. Анхны алхмууд хийгдээд явж байна. 2017 онд Японы Нагоягийн их сургуулийн хичээлийн судалгаа, хичээлийн анализын чиглэлээр ажилладаг багш нартай холбоо тогтоосон. Миний бие МХСН-ээ төлөөлж Японы нэг удаагийн сургалтыг Нагоягийн их сургуультай холбож монгол, япон багш нар хичээлийн анализыг анх удаа хийж үзсэн. 2016 онд Говьсүмбэр аймгийн 1 дүгээр сургуульд заасан математикийн хичээлийн видео болон аудио бичлэгийг тэмдэглэл болгон хөрвүүлж хичээлийн анализийг Нагоягийн багш нартай хамтран хийсэн. Энэ чиглэлээр МХСН Нагоягийн их сургуулийн багш нартай хамтарсан судалгаа хийх эхлэл тавигдаж байна. Дэлхийн хичээлийн судалгааны нийгэмлэгийн их хуралд тогтмол оролцож байгаа. Хэдэн жилийн дараа энэ хурлыг Монголд зохион байгуулах талд санаа тавьж ажиллах бодолтой байгаа.

# СУДАЛГААНД-СУРГУУЛИЙН ЗАХИРЛУУД

№ 001
Web: http://mals.mn/

*Улсын тэргүүний "Ган зам" 20 дугаар сургуулийн захирал, Монгол Улсын гавьяат багш Н.Батбаяр*



# ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА БИДНИЙГ ТӨГС ХИЧЭЭЛ РҮҮ ХӨТӨЛДӨГ

**-Хичээлийн судалгааны төслийн ач холбогдлыг талаарх Таны бодол?**

-Хичээлийн судалгаа гэж сургалтын том үйл ажиллагаа 2006 онд Боловсрол шинжлэх ухааны яам, Жайка олон улсын байгууллагатай хамтарсан "Суралцагсдын суралцахуйг дэмжих арга зүй" гэсэн төсөл Монгол Улсын боловсролд анх удаа орж ирсэн. Жайка төслөө оруулж ирэхдээ суурь судалгааг маш сайн хийсэн. Суралцагч ямар идэвхтэй байна гэдгийг суралцагчдын сурах арга барил, идэвх, чармайлт, багшлах арга зүй, хөтөлбөрийн агуулга ямар байгаа суурь судалгааг Улаанбаатар хотын 3 сургуульд хийсэн. Баянгол дүүргийн Сэтгэмж цогцолбор сургуульд намайг захирлаар ажиллаж байхад уг судалгаа хийгдсэн. Төслийн ач холбогдол нь:

1. Анх удаа боловсролын байгууллагууд хамтарч оролцсоноор онцлог. Өөрөөр хэлбэл: МУИС, МУБИС, Боловсролын хүрээлэн, Багшийн сургууль, Боловсролын үнэлгээний төв, ЕБС-иуд хамтарч хичээлийн судалгааг явуулсан.

2. ЕБС хичээлийнхээ агуулга, арга зүйгээ дээрээс өгсөн чиглэлийн дагуу боловсруулж заадаг байсан бол энэ төсөл орж ирснээр их, дээд сургуулийн эрдэмтэн багш нартай хамтарч агуулгын шинэчлэл хийсэн. Агуулгатай тохирсон хөтөлбөрөө боловсруулж, ямар арга зүйгээр заах вэ гэдгээ шийдсэн. Олон улсын байгууллага Жайка, Японы Гакугийн их сургуулийн багш нар хамтарч өргөн далайцтайгаар ЕБС-д энэ төслийг оруулж ирсэнээрээ ач холбогдолтой.

3. Энэ төсөл орж ирснээр багшийн заах арга зүй өөрчлөгдсөн. Багш нар нэг арга зүйгээр явдаг байсан бол төрөл бүрийн арга зүйг оруулж ирсэнээрээ онцлог юм. Хүүхэд төвтэй сургалтын арга зүй гэдгийг анх удаа оруулж ирлээ. Ингэснээр ЕБДС-д гадаадын өндөр хөгжилтэй орнуудын сургалтын арга зүйг өөрийн онцлогт тохируулан нутагшуулсан.

**-Хичээлийн судалгаагаар ямар сургуулиуд загвар сургууль болсон бэ?**

-Хичээлийн судалгаагаар анхны загвар сургуулиар Сүхбаатар дүүргийн 45 дугаар сургууль, Баянгол дүүргийн Сэтгэмж цогцолбор сургууль, Баянзүрх дүүргийн 97 дугаар сургууль дээр анхны туршилтууд хийгдсэн. Дараа нь Дорнод, Сэлэнгэ аймгийн ЕБС-ийн 3 сургууль нийт 9 сургуульд энэ төсөл хэрэгжсэн. 2006 оноос хэрэгжсэн төсөл 2009 онд дуусаад 2010 оноос "Багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх төсөл" гээд Нийслэлийн СХД, Булган аймгийн 3 сургууль, Завханы 3 сургууль загвар сургуулиуд болж улмаар Монгол Улсын бүх сургуулиуд дээр түгээн дэлгэрүүлэлт хийгдсэн. Ийм түүхийг туулж хичээлийн судалгаа гэж сургалтын дэвшилтэт технологи манайд нэвтэрсэн юм. Одоо бүх ЕБС-уудад хичээлийн судалгаа явагдаж байна. Анх зөвхөн багш төвтэй судалгаа хийгдэж байсан бол одоо энэ хөтөлбөрт таарсан арга зүйг багш нар хамтарч бэлтгэж, агуулгатай тохирсон арга зүй, хэрэглэгдэхүүний судалгааг хийгээд явж байна. Үүгээрээ хичээлийн судалгаа үр дүнтэй болсон. Энэ чиглэлээр олон ном, сурах бичгүүд гарсан.



表彰状

ウランバートル市、バヤンゴル区、
「セトゲムジ」学校校長
N. バタバヤル 殿

あなたは、ＪＩＣＡとモンゴル教育文化科学省が共同で実施している「子どもの発達を支援する指導法改善プロジェクト（1年次）」における指導書作成にあたって、本プロジェクトの主旨を理解し、貴校教員の試行授業を積極的に支援されました。その成果は指導書の改善に多大な貢献をされました。よってここに感謝の意を表し記念品を贈呈しここに表彰いたします。

2007年9月2日　ウランバートル市

JICAモンゴル事務所　所長　守屋 勉
教育文化科学省　副大臣　S. トムル・オチル



БАТЛАМЖ

Нийслэлийн Баянгол дүүрэг
"Сэтгэмж" цогцолбор сургуулийн захирал
Н. Батбаяр Танаа

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага "ЖАЙКА", Монгол Улсын БСШУЯ-аас хамтран хэрэгжүүлж буй "Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил" төслийн хүрээнд Монголын нийт багш нарт зориулан бүтээсэн шинэ арга зүйн анхны жилийн зөвлөмжийг турших ажилд сургууль, багш нараа манлайлан хүчин чармайлт гаргасныг гэрчлэн Танд "БАТЛАМЖ" олгож, талархал илэрхийлэн дурсгалын зүйл гардуулав.

"ЖАЙКА"-ын Монгол дахь төлөөлөгчийн газар
Дарга
Мория Цутому

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
Дэд сайд
С. Төмөр-Очир

Улаанбаатар хот. 2007.09.12

**-Үр дүнгийн талд танай сургуулийн жишээн дээр авч үзвэл...**

-Сургуулиудад судлагдахуунд суурилсан хичээлийн судалгааг явуулдаг. Ач холбогдол нь багшийн арга зүй дээшилж байгаа юм. Багш зөвхөн ганцаараа ярьдаг байсан бол хүүхэд төвтэй хичээлийн судалгаа болсон. Хүүхэд ярьдаг, чөлөөтэй илтгэдэг, санал бодлоо чөлөөтэй хуваалцдаг болсон. Хичээл заахдаа юун дээр алдаад байна вэ гэдгийг судлаж байгаа. Арга зүй, цагийн менежмент, үнэлгээ, хэрэглэгдэхүүний сонголтон дээрээ юу гэдэг алдааны шинжилгээ хийж байна. Үүнийгээ заах аргын нэгдэл, секц болон хамтаараа ярилцаж хэлэлцээд дараагийн ангид орохдоо алдахгүй байхад суралцаж байгаа. Бид хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, арга зүйгээ боловсронгуй болгож явсаар "Төгс" хичээл рүү явж байна. Энэ завшааныг ашиглан Хичээлийн судалгааны нийгэмлэг байгуулагдсаны 5 жил ойг тохиолдуулан Монголынхоо бүх багш нарт анх өлгийдөж авсан хүний хувьд баярын мэнд хүргэж байгааг хүлээн авна уу.

# БИД АНХДАГЧИД



*СБД-ийн 45-р сургуулийн захирал асан Ц.НАМЖИЛДОРЖ*

■ 2006-2009 онд БСШУЯ, Япон улсын хамтын ажиллагааны "ЖАЙКА"-аас хамтран МУИС болон МУБИС-ийн дэргэдэх дидактик, сургалт, судалгааны дөрвөн төвийг түшиглэн Улаанбаатар хотын 45, 97, Сэтгэмж цогцолбор гэсэн гурван сургууль дээр "Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил" төслийг амжилттай хэрэгжүүлсэн юм.

■ Бид энэ төслөөсөө сурагчдын суралцахуйд сургах, тэдний үйл ажиллагааг дэмжих арга зүйг олж харсан бөгөөд түүнийгээ түгээн дэлгэрүүлсэн юм.

■ 2009-2012 онд "Багшлахуйн арга зүйн хөгжлийг дэмжих" төслийг үргэлжлүүлэн судлан шинэчлэх ажлаа эхлүүлэн амжилттай хэрэгжүүлж сайн сургууль, сайн хичээл гэдгийг багаар ажиллах, зөвхөн багшлахуй биш хичээлээ судлах ёстой, хэрэглэгдэхүүнээ судлах, хүүхдээ судлах, алдаагаа судлах, гарын доор материал ашиглах, алдаагаа засан сайжруулах зэрэг олон санааг олж хэрэгжүүлж байлаа.

■ Манай төсөл нь багшийн нэгж болон ээлжит хичээлээ төлөвлөх, зохион байгуулах, оношлох, арга зүйд хувь нэмэр оруулан, суралцагчдын бие даан суралцах чадварыг илрүүлэн хөгжүүлэх боломжийг нээх зорилгоор дунд ангийн математик, физик, хими, мэдээлэл зүй, хүн байгаль, хүн орчин, бага ангийн математик, төсөлт ажил гэсэн найман хичээлээр арга зүйн зөвлөмж боловсруулан бодит хичээлээр туршин сайжруулсан юм.

■ Хэдийгээр туршилт хичээлийг зохион байгуулах үед маш их ажлын ачаалалтай ажилладаг байсан ч МУИС, МУБИС-ийн эрдэмтэн багш нартай хамтран ажиллаж, ажлын байран дээрээ мэргэжлийн онол, заах арга зүйн хувьд хөгжих боломж бидэнд оногдож байсан тул нийт хамт олноороо сэтгэл зүрхээ нэгтгэн хүүхдийн төлөө зориулан ажиллах эрч хүчийг өгдөг байсан билээ.

■ Төсөл хэрэгжсэнээр манай хамт олны багаар ажиллах, бие биендээ тусалж дэмжих, нэгэн зорилгын төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр, хамтран ажиллах чадвар нь улам сайжирсан билээ. Аливаа ажлын амжилт, алдаа оноо зөвхөн хэн нэгэн хүнийх биш, багийнх юм гэдгийг хүн бүхэн хүлээн зөвшөөрдөг болсон.

■ Бид Монгол улсын сайн сургуулийн загварыг дараах байдлаар төсөөлдөг байсан:

САЙН СУРГУУЛЬ НЬ:

✓ Өөр өөрийн гэсэн ертөнцийг харах үзэлтэй болгодог

✓ Сурах нь чухал ч суралцахуйд суралцах нь хамгийн чухал гэдгийг ойлгуулдаг

✓ Сурагчдад хамгийн сайн найз ойр тойрны хүрээллийг үүсгэдэг

Мэдлэг чиний ертөнцийг өөрчилж, үзэл бодол чинь чиний хандлагад нөлөөлж, хандлага чинь чиний нэг насны амьдралыг тодорхойлдог гэдэгт суралцан, бусдад түгээх хамтарч ажиллахыг зорилго болгодог.

■ Их сургуулийн оюутан бүр сурагч байсан, сурагч бүр хүүхэд байсан.

■ Дунд сургууль л бидний ирээдүй хэн байхыг тодорхойлдог.

■ Тийм учраас манай төслийн баг хамт олон, тэр үеийн Сэтгэмж цогцолбор сургуулийн захирал Н.Батбаяр бид бүгд Япон зөвлөх Иший сан, Сузуки сан болон бусад зөвлөх багш нартайгаа хамтарч монголын боловсролын шинэчлэлийг хийхийн төлөө маш шаргуу амжилттай ажилласан юм.

■ Одоо ч гэсэн сайн сургууль (удирдлагын баг), сайн хичээл, хичээлийн судалгааг амжилттай үргэлжлүүлж, сургууль багш нартаа түгээн дэлгэрүүлж МХСН-ийг амжилттай удирдаж байгаа доктор Н.Оюунцэцэг түүний удирдлагын баг хамт олонд цаашдын нь судалгаа шинжилгээний ажилд улам өндөр амжилт хүсье.

## ЯПОН ДАХЬ СУРГАЛТЫН ТАЛААРХ СЭТГЭГДЭЛ

**МХСН-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН Г.НОРЖМАА**



Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгтэй хамтран ажиллаж буй холбогдох хүмүүс, багш нарыг Япон улсад урьж нийт 6 удаагийн сургалтыг зохион байгуулаад байна. Японд сургалт зохион байгуулснаар Монгол улсад нэвтрүүлэн хэрэгжүүлээд байгаа Хичээлийн судалгааны арга туршлагыг бодитоор харуулсан чухал үйл ажиллагаа юм. Оролцогчид Японы бодит байдалтай танилцан шинэ санаа олж аван, шилдэг туршлага хуримтлуулахаас гадна төр, захиргааны байгууллага, их сургууль, дүүрэг, орон нутгийн боловсрол соёлын газрын төлөөлөл, дунд сургуулийн захирал, багш нар ажлын байрнаасаа түр холдон ижил зүйл үзэж харж, ижил зүйл сонсож, Монголын нөхцөлд ямар асуудал байна, шийдвэрлэх ямар арга зам байгаа талаар бодож үзэх, хэлэлцэх боломж бүрдүүлж өгөх нь сургалтын бас нэг зорилго байсан юм. Өнөөг хүртэл манай нийгэмлэгээс зохион байгуулсан сургалтад нийт 85 хүн оролцжээ.

*СҮҮЛИЙН БУЮУ 6 ДАХЬ УДААГИЙН СУРГАЛТЫН ТАЛААР ТОВЧ ТАНИЛЦУУЛЪЯ.*

2018.05.30-06.06-ны өдрүүдэд тус нийгэмлэгийн 6 дахь удаагийн сургалт “Япон улсын боловсролын тогтолцоо, математик, байгалийн ухааны сургалтын үнэлгээ” сэдвээр явагдлаа. Сургалтаар Японы сургуулийн ялгаатай хэв шинжийн хэд хэдэн сургуулиар зочилж, сургуулийн амьдрал, багш, хүүхдүүдийн байдалтай танилцан, хичээлд ажиглалт хийн, оилголтоо гүнзгийрүүллээ. Токио хотын Минато дүүргийн боловсролын хороогоор айлчлан дүүргийн сургуулиудаа хэрхэн дэмжиж ажилладаг талаар лекц сонсон, дараа нь тус дүүргийн бага, дунд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцан сонирхолтой лекц сонсож, ажил байдалтай нь танилцлаа. Токио хотдоо алдартай байгалийн ухааны хичээлийн судалгаа сайн хийдэг, Судалгаат хичээл зааж хол ойроос олон зочид ирж үздэг Тэраши багшийн Судалгаат хичээлд ажиглалт хийж байгалийн шинжлэх ухааныг хэрхэн яаж бодит амьдралтай холбон зааж байгааг үзлээ.

Урава их сургуулийн багш доктор Ватари Фүмико математикийн хичээлийн “Хичээлийн бэлтгэл судалгаа” сэдвээр хичээл заалаа. Мөн Токио Гакугэй Их сургуулийн харьяа түшиц Сэтагаяа дунд сургуулиар зочилж ажил байдалтай нь танилцсанаас гадна, нийгмийн ухааны хичээлд ажиглалт хийлээ. Сургалтын сүүлийн өдөр, оролцогчид эх орондоо буцаж очоод хийх үйл ажиллагаагаа илтгэл хэлбэрээр танилцуулдаг. Хичээлийн судалгааны төсөл хэрэгжиж дуусаад бид энэ арга зүйг цаашид хөгжүүлэнгээ үргэлжлүүлэн авч явах үүрэг хүлээсэн байгууллага билээ. Тиймээс цаашид ч багш нараа зориод ирэхэд итгэлийг нь даасан, багш нараа дэмжсэн олон сайхан сургалтыг зохион байгуулах хүслээр дүүрэн явдаг.

## СУРГАЛТААС БАГШ НАР ЮУ ОЛЖ АВДАГ ВЭ?



*Сургалтад хамрагдсан багш нарын сэтгэгдлээс харахад энэхүү сургалт үр нөлөөтэй сургалт болох нь харагдаж байна.*

✦ Асар их тэвчээр хүчин зүтгэлийн үр дүн энэ өндөр боловсролын системийг бий болгосныг ойлгосон

✦ Хэт өндөр түвшинд хичээлээ шахаж, мэдээлэл дамжуулах үүднээс зааж байгаа маань алдаа юм. Цаашид хичээлийг хүүхдэд зориулж, удаан ч гэсэн эрдэм болгож үлдээж заах хэрэгтэй юм байна

✦ Багшийг шалгаж дүгнэх биш, багш сурагчдын төлөө үргэлж дэмжиж, тусалж ажилладаг

✦ Хүүхдүүдийг сэргэлэн цовоо, хэлэх гэсэн зүйлээ шууд хэлдэг болгодог

✦ Бодлого гаргаад багшид даатгаад хаядаг биш яамнаасаа багш хүртэл бүгд холбоотой нэг чиглэлээр ажиллаж, ижил нэгж, ээлжит хөтөлбөрөөр зааж байгаа нь хүүхдэд ялгавартай биш жигд хөгжих боломж олгодог

✦ Хичээл дээр хүүхдүүд хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэлтэй харьцаж байгаа, ажигласан зүйлээ тэмдэглэн бичиж байгаа, хичээлд мэдэхийн төлөө оролцож, эргэлзээтэй зүйлийг өөрөө явж бусдаас мэдэж авч байгаа зэрэг үйлүүд нь бүр хэвшил болохоос гадна "би хийх ёстой" гэсэн сэтгэлтэй байгаа нь таалагдсан

✦ Залуу багш, ахмад багш, зөвлөх, судлаачид үр дүнтэй хамтран ажилладаг. Хамтран төлөвлөх, хичээл ажиглалт хийх, хичээл зааж үзүүлэх, хичээлийн бэлтгэл судалгаа хийх, ямар даалгавар өгөх гэж байгаа, ямар асуулт асуух гэж байгаа, хүүхэд юу гэж хариулах бол гэх мэт зүйлсийг зөвлөдөг.

✦ Японы сургуулийн эрхэм зорилго нь “Сайхан сэтгэл, эрдэм мэдлэг, эрүүл биеийг төлөвшүүлдэг сургууль”, “Аливааг даван туулах чадвартай хүүхэд болгон төлөвшүүлэх” гэх мэтчлэн хүүхдийн төлөө байдаг.

✦ Японы хүүхдүүд бусаддаа туслах гэсэн сэтгэлээр, хандлагаар хичээлдээ оролцдог болохыг бодитоор харсан. Хүүхэд өөрөө мэдэх, сурах нь чухал биш багийнхаа найзад, асуудалтай байгаа ангийнхаа найзад туслая, түүнийг сургая гэсэн сэтгэлээр хичээлдээ оролцож байсан. (Математикийн 4-р ангийн хичээл)

✦ 5-р ангийн физикийн “Хүнд, хөнгөн” туршилтат хичээлийг үзэхэд хүүхдийг чөлөөтэй туршуулж, бүх боломжийг турших үзэх боломж олгож байгаа нь хүүхдийг хэдэн удаа турш, тэг ингэ гэж хайрцаглахгүй байгаа нь миний хувьд суралцах нэг том арга зүй байсан. Учир нь би туршилтат хичээл дээр хүүхдүүдээр хурдан туршуулаад, үр дүнг гаргах гэж яардаг байснаа ойлгосон.

✦ Япон багш нар үйл ажиллагаандаа судалгаатай ханддаг. Түүнийгээ шийдэж чаддаг хүмүүс юм Уйгагүй хөдөлмөрлөж судалж, үр дүнг нь хардаг юм байна. Хүүхдийг багаас нь эмх цэгцтэй байдалд сургаж чадаж байгаа нь зөвхөн нэг цагийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг эмхэлж цэгцэлж байгаа байдлаас харагдлаа. Хичээлийг хүүхэд өөрөө хийсээр байгаад шинэ мэдлэгээ бүтээж түүнийгээ тайлбарладаг талаар олон шинэ санаа авсан.

**Бид тэднээс сурах зүйл их байлаа гэх мэт маш олон сэтгэгдэл ирүүлдэг (mals.mn сайтаас).**

## ФИЗИКИЙН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА ГҮНЗГИЙРСЭЭР...

**МХСН-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, МУИС-ИЙН ЗӨВЛӨХ БАГШ М.ГАНБАТ**



Жайкагийн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил (2006-2009)” төслийн 8 дэд багийн нэг физикийн сургалт, судалгааны дэд багт бид ажилласан юм. Физикийн дэд багийн ахлагчаар М.Ганбат, гишүүдэд Б.Ариунбаяр, Я.Мөнхсайхан, Г.Чулуунбаатар, П.Лхагвасүрэн, туршигч багшаар ЕБС–ийн Сэтгэмж, 45, 97 сургуулийн П.Мөнхбаяр, Д.Оюунтунгалаг, Х.Баярцэнгэл, С.Батчулуун, Сэлэнгийн Н. Мөнхжаргал, Д.Баттулга, Н.Уранчимэг, Дорнодын Ц.Хоролжав, Б.Мөнхтуяа нар ажилласан билээ. Төслийн хүрээнд Японы арга зүйгээс суралцаж “Хялбар туршилтаар мэдлэг бүтээх арга зүй Зөвлөмж-1”, “Сургалтад сурагчдын өмнөх төсөөллийг тооцох арга зүй Зөвлөмж-2”, “Контекст төвтэй сургалтаар мэдээлэл харилцааны цогц чадамж төлөвшүүлэх арга зүй Зөвлөмж -3”, VCD бүтээж, бүх багш нарт хүргэж билээ.

Төслийн 2-р шатанд (2010-2012)” төслийн хүрээнд хичээлийн судалгааны арга зүйг Сонгино хайрхан, Баянзүрх дүүрэг, Булган, Завхан аймгийн сургуулиудад туршиж, үр дүнг нэгтгэж “Багшлахуйн хөгжил: Физикийн хичээлийн модуль” боловсруулж түгээсэн. Модулийг боловсруулах, турших ажилд дээрх багш нараас гадна Ж.Дөлгөөн (МУИС), М.Энхбаяр (Ирээдүй цогцолбор) зэрэг багш нар шинээр орж их үүрэг гүйцэтгэсэн. Түүнээс гадна бид удирдлага, менежмент, багш бэлтгэх сургуулиудад зориулсан модуль боловсруулахад оролцсон.

МУИС-ийн физикийн багшийн ангид хичээлийн судалгаа гэсэн хичээл заадаг болсон. Сүүлийн 5 жилд энэ чиглэлээр бакалаврын 4, магистрын 2 дипломын ажлыг удирдсан ба ойролцоогоор хот хөдөөгийн багш нарын 50 орчим илтгэл хэлэлцэгдэж, 4 багш эхний 3 байрт шалгарсан.

ЕБ-ын 45, 20, Ирээдүй цогцолбор, Байгаль Эх сургуулиас гадна Завхан, Хөвсгөл, Ховд, Дорнод, Говь Сүмбэр, Өвөрхангай, Дархан Уул, Булган зэрэг аймаг физикийн хичээлийн судалгааг тогтмол явуулж хамтран ажилласаар байна. Сүүлийн жилүүдэд бага хурал ирж байгаа илтгэлүүдийн чанар, өрөөж, туршигдсан байдал улам төгөлдөржиж байгаад талархаж байна.

# ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА ДЭЛХИЙД

№ 001
Web: http://mals.mn/

# WALS ХУРАЛ












**Хичээлийн судалгаа, хүүхдийн хөгжлийн чиглэлээр судалгааны үр дүнгээ дэлхийн тавцанд хүргэх нэг арга зам бол WALS болж байна. Хичээлийн судалгааны дэлхийн нийгэмлэг (The World Association of Lesson Studies-WALS) нь багшлахуй, суралцахуйн чанарыг дээшлүүлэх зорилт бүхий хичээлийн судалгааны практик үйл ажиллагаа болон шинжилгээ судалгааны үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2000 онд байгуулагджээ. Энэ үеэс улс орнуудын боловсролын судлаачид, сургуулийн захирал, сургалтын менежер, багш нар хичээлийн судалгааны арга зүйн талаар харилцан туршлага солилцох, тулгамдсан бэрхшээл, асуудлаа хамтдаа туулан хөгжихөөс гадна хөгжлийн хэтийн чиг хандлагын талаар олон улсын түвшинд хэлэлцдэг болсон юм. Манай судлаачид 2012 оноос эхлэн дэлхийн хичээлийн судалгааны нийгэмлэгийн хуралд тогтмол оролцож монгол дахь хичээлийн судалгааны түүх, хөгжил, бэрхшээлүүдээ хуваалцахаас гадна олон улсын судлаачдаас судалгааны арга зүй, практик туршлагуудыг сурч өөрийн орны боловсролын хөгжилд зохих хувь нэмэр оруулж байна.**

*Жил бүр болдог Дэлхийн Хичээлийн Судалгааны Нийгэмлэг (WALS2017)-ийн 11 дэх хурал 2017 оны 11 сарын 23-27-ны өдрүүдэд Нагоя Их сургууль дээр боллоо. Энэ удаагийн хуралд 35 орны 900 орчим судлаач оролцож нийт 386 илтгэл хэлэлцүүлжээ. Илтгэлүүд нь үндсэн (3), форум, симпозиум, дугуй ширээний хэлэлцүүлэг (28), аман (295), ханын илтгэл (60) гэсэн хэлбэрүүдтэй байдаг байна.*







*Хүснэгт 2. WALS-ийн хуралд хэлэлцүүлсэн илтгэлийн товчоо*

| ОН | ИЛТГЭЛИЙН СЭДЭВ | ИЛТГЭГЧ | ХААНА |
|---|---|---|---|
| WALS-2012 | Some results if implementing the lesson Study by chemistry teacher's Bayangol district | Ч.Нямгэрэл (МУИС) Ж.Энэбиш | Сингапур |
| WALS-2013 | Has the lesson study changed the teacher's of Mongolia? | Тэцуя Иший, Н.Оюунцэцэг, Саяака Сузуки | Швед |
| WALS 2014 | Improving mathematics learning tools through lesson study | Т.Ганбаатар | Индонез, Бандуг |
| WALS-2015 | Condition of lesson study in Mongolia | Т.Ганбаатар, Н.Оюунцэцэг, Б.Хишигбаяр, О.Оюунтунгалаг | Тайланд, Бандунг |
| WALS-2015 | Assessing opportunities of lesson on classroom practices in an undergraduate science education course in Mongolia | Ц.Пагамсүрэн | Тайланд, |
| WALS-2016 | Results of the research Mongolian Classroom Discourse In Historical And International Context: Through Lesson Analysis Of Mathematics Lessons | Н.Дуламжав (МУБИС) Т.Ганбаатар (МУБИС) О.Алтангоо (МУБИС) | Англи (United Kingdom) |
| WALS-2017 | A Methodology to Measure Lesson Quality through Students' Engagement Using Transcript Based Lesson Analysis | Т.Ганбаатар (МУБИС) | Япон, Нагоя |
| | Some result of study to teaching method development by Lesson Study | Ш.Сайнбилэг, Н.Оюунцэцэг | Япон, Нагоя |
| | Situation of Lesson Study at Graduate School of Mongolia | Г.Баярмаа, Н.Дуламжав Отани Такаши | Япон, Нагоя |
| | Curriculum Improvement Through The Competence Based Assessment in Mongolia | Д.Нямжав (МУБИС) Ц.Оюунбат (МУБИС) Н.Дуламжав (МУБИС) Д.Пүрэвсүрэн (Гурван-Эрдэнэ) | Япон, Нагоя |

*2018 оны 11 дүгээр сарын 24-27-нд Бээжин хотод болох WALS-2018 хуралд олон төлөөлөгчид илтгэлээ хэлэлцүүлэхээр явах гэж байна. Мөн Өвөрхангай аймгийн ЕБС-ийн 1-р сургуулийн А.Батцэцэг нарын багш нар хуралд анх удаа оролцох болсон байна.*

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ МХСН-ИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ



**Л.СУВД *(СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТЭРГҮҮН)***

Японы ЖАЙКА ОУБ, БСШУЯ хамтран хэрэгжүүлсэн төслийн загвар аймгаар Сэлэнгэ аймаг шалгарч, багшлах арга зүйн баялаг туршлага хуримтлуулсан билээ. Тус аймгийн багш нар Хичээлийн судалгааны нийгэмлэгийн анхны салбар зөвлөлийг аймагтаа байгуулж Удирдах зөвлөлийг 19 хүний бүрэлдэхүүнтэй сонгов. Салбар зөвлөлийн гишүүнээр Бугант, Түшиг, Дулаанхаан, Мандал сумын 4 дүгээр сургуулийн хамт олон элссэн бөгөөд Сүхбаатар сумын 1, 4, Хушаат сумын сургууль, Аймгийн БСУГ хамтран ажиллаж байна. Салбар зөвлөлийн тэргүүнээр Л.Сувдааг сонгосон байна. Сэлэнгэ аймгийн салбар зөвлөл 2018 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Мандал сумын 1 дүгээр сургууль дээр "Хичээлийн судалгаа-Судалгаат хичээл" сургалт хийлээ. Сургалтад Мандал сумын 4, Дулаанхаан тосгоны сургуулийн хамт олон, Бугант, Түшиг сумын сургуулийн захирал, сургалтын менежерүүд оролцлоо. МХСН-ийн гишүүн хамт олон болох Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны ЕБС-ийн сургууль хичээлийн судалгааг зохион байгуулж байна. Сургуулийн түвшинд хичээл судалгааны 4 баг ажиллаж, 16 удаагийн судалгаат хичээл зааж хэлэлцүүлэн, багш нарын багаар ажиллах үйл ажиллагааг дэмжин, харилцан суралцах, туршлага солилцох , түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанууд хийгдсэн. Сэлэнгэ аймгийн Мандал IY сургууль дээр зохион байгуулагдсан "Хичээл судалгааны арга зүй" сэдэвт сургалтанд сургалтын менежер П.Даваажаргал хамрагдаж ирснээр багш нартаа зөвлөн тусалж, хамтран ажиллаж байна. Сурагчид өөрсдөө мэдлэг бүтээж, мэдээ мэдээлэл цуглуулж, хичээл сургалтыг хамтран зохион байгуулж, үүрэгтэй оролцож эхэлснээр сэтгэл ханамж өндөр байна. 2017-2018 оны хичээлийн жилд хичээл судалгааны нийгэмлэгээс зохион байгуулсан "Суралцахуйг дэмжих багшлах арга зүй" илтгэлийн уралдаанд "Үг цээжлүүлэх идэвхтэй аргуудаар сурагчдыг хөгжүүлэх нь" сэдэвт илтгэлээр Н.Эрдэнэбилэг ахлагчтай судалгааны баг амжилттай оролцож, хүүхэд хөгжүүлэх туршлагаа хуваалцсан. Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ЕБС-ийн сургуульд хичээлийн судалгааны мониторингийн баг ажиллаж байна. Хичээлийн судалгааны "МОНИТОРИНГ" баг 8 дахь жилдээ ажиллаж байна. "МОНИТОРИНГ" баг нь багшийн арга зүйг дээшлүүлэх, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх зорилтыг дэвшүүлэн ажилладаг. Дулаанхаан тосгоны ЕБС-д сургуулийн зорилгыг сурагчдын чадварт тулгуурлан боловсруулдаг.

# ӨӨРИЙН ГЭСЭН АРГА ЗҮЙ, ТЕХНОЛОГИЙГ БИЙ БОЛГОХООР ЗОРЬЖ БАЙНА

**Дорнод аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн захирал М.АЮУШХОРЛОО**



Монгол улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-тай хамтран 2006-2012 онд 2 үе шаттай хэрэгжүүлсэн "Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил", " Багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх" төсөл манай аймаг орон нутагт амжилттай хэрэгжсэн билээ. Төслийн үр дүнд багш нар хичээлийн судалгааны арга зүйд суралцаж, бүсийн сургагч багш нар бэлтгэгдсэн юм.

Манай сургуулийн хамт олон уг төслийн үзэл санаа, үйл ажиллагааг бүтээлчээр хэрэгжүүлэх, өөрсдийн туршлагаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Хичээлийн судалгаа"-г сургалтын үндсэн үйл ажиллагааны салшгүй хэсэг болгох менежментийг боловсруулан 2013 оноос амжилттай хэрэгжүүлсэн билээ. Ингэснээр багш нар судлагдахууны багаар хамтран ажиллаж, хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйд суралцаж, "өөрийн гэсэн" арга зүй, технологийг бий болгохыг зорьж байна.

Хичээлийн судалгааг тогтмол чанартай зохион байгуулснаар багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжин, тэдний судалгааны ажлын үр дүн, арга туршлагыг бусадтай хуваалцах, түгээн дэлгэрүүлэх боломж бүрдсэн.

Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт хамтран зохион байгуулдаг "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй" үндэсний онол практикийн бага хуралд бид 5 жил дараалан амжилттай оролцож сургуульд болон судлагдахуунд суурилсан судалгааны ажлын үр дүн, сайн туршлагаа түгээн дэлгэрүүлж, эрдэмтэн судлаачдын зөвлөгөөг тусган хөгжүүлж, сайжруулсаар байна.

БМДИ, МХСН-ээс хамтран жил бүр зохион байгуулдаг "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй" онол практикийн бага хуралд 5 жилийн хугацаанд тус сургуулийн багш нарын 58 хувь нь амжилттай оролцсон. 2018.01.12-нд хамгийн олон илтгэл хэлэлцүүлж «Түгээн дэлгэрүүлэгч» хамт олон болов.




# ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА ЗАВХАН АЙМАГТ



Я.Нарангэрэл

Завхан аймагт 2010-2013 онд Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллага, БСШУЯ хамтран "Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх" төсөл хэрэгжүүлсэнээр баруун 5 аймгийн хичээлийн судалгааны загвар аймаг боллоо. Төсөл хэрэгжүүлэх хугацаанд загвар 6 сургууль /Улиастай сумын Чандмань-Эрдэнэ лаборатори, Тосонцэнгэл сумын лаборатори I, Сонгино, Баянтэс, Шилүүстэй, Завханмандал сумын/ бий болж тойргийн сургуулиудынхаа багш нарын ур чадварыг сайжруулах үйл ажиллагаанд чиглүүлэгч үүрэг гүйцэтгэж ирлээ.

Энэхүү төсөл Завхан аймагт хэрэгжих болсонтой холбоотой нэгэн түүхийг сөхөхөд Я.Нарангэрэл миний бие 2005 онд БСГ-ын мэргэжилтнүүдийн дунд зарлагдсан багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр эсээ бичлэгт оролцон улмаар сонгогдож, Япон улсад 40 гаруй хоногийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж ирсэн билээ. Японд байхдаа багш ажлын байрандаа тасралтгүй хөгждөг шилдэг ямар арга зам байдаг юм бол гэж эрэлхийлж байсан асуултынхаа хариуг олж авсан. Энэ нь хичээлийн судалгаа байсан юм. Аймагтаа ирээд хичээлийн судалгааны үзэл санааг багш нарт ойлгуулах зорилгоор "Багшийн хөгжил тасралтгүй үйл явц", "Чанартай хичээл шинэчлэлийн үндэс" нэртэй сургалтуудыг зохион байгуулж, сургууль бүрд багшийг ажлын байранд нь хөгжүүлэх баг байгуулан ажилласан. 2010 онд БСГ-уудын дунд хичээлийн судалгааны төслийн уралдаан зарлагдсан нь миний сонирхлыг маш их татаж, төсөл бичиж БСШУЯ-д хүргүүлсэн юм. Төсөл маань дэмжигдэж ийнхүү манай аймагт хэрэгжсэн. Тухайн үед бидний үзэл санаа, зорилгыг маш сайн ойлгож, дэмжиж байсан олон хүмүүсийн дундаас Н.Нэргүй багшдаа онцгойлон туйлын их баярлаж явдаг.

Үйл ажиллагааны төлөвлөгөө, ойлголтоо сайжруулдаг сургалт, сурсанаа ажлын байрандаа туршдаг хугацаатай аян, турших байх хугацаанд нь хэрэгжүүлдэг мониторинг, хичээлийн жилийн төгсгөлд тавьдаг тайлан гэсэн хоорондоо тасралтгүй явдаг цогц үйл ажиллагаа нь хичээлийн судалгаа амжилттай хэрэгжих гол арга технологи нь байсан юм. Энэхүү технологийг эзэмшсэн багш нар сурсанаа бусдадаа түгээн дэлгэрүүлэх нь бас нэгэн чухал арга зам байсан одоо ч байсаар байна.



# ЧӨЛӨӨТ ЦАГ

№ 001

Web: http://mals.mn/

**Б.ХИШИГБАЯР**
**МХСН-ийн УЗ-ийн дарга**



## ТӨСЛИЙН ЯПОН ТАЛЫН ЗӨВЛӨХ, БАГШ НАРЫН ТУХАЙ ЭРГЭН ДУРСАХАД...

Манай Иший сан даруу, төлөв, асуудлыг эвээр шийддэг, чадварлаг удирдагч төдийгүй үргэлж эрүүл мэндээ анхаар гэж зөвлөдөг сайхан сэтгэлтэй хүн. Сүүлд яриандаа “2010 оны 4 дүгээр сард 2 дахь шатыг эхлүүлэхээр Монголд ирэхэд оффис маань хараахан бэлэн болоогүй учир айлд /тэр нь манайх/ ажлаа эхэлж байсан нь сонирхолтой байсан” гэж дурсаж байсан. Иший сан, Норжмаа бид 3 “Inception report” яаралтай орчуулах ажилтай сандарсан хэрэг л дээ. Япон хүний хувьд “айлд ажиллах” нь их л сонин бололтой, бидний хувьд ч бараг л хэвийн биз дээ.

Сүзүки сан маань хурдан шуурхай, нэгэн зэрэг олон ажил хийж, олон хүнтэй харилцдаг, Монголчуудтай ажиллах аргаа мэддэг, чадварлаг мэргэжилтэн билээ. Нэгэн удаа Япон яваад шүдний аппарат хийлгэж ирээд /35 настай/ “намайг одоо аппарат хийлгэхгүй бол 80 нас хүрээд шүд чинь унана” гэж эмч хэлсэн гэлээ. Бид эхлээд анзаараагүй байснаа гэнэт “юу вэ? Монголчууд бидэнд тийм ойлголт алга, 80 хүрээ ч үү үгүй ч үү? 80 хүрлээ гэхэд шүдтэй байх эсэх тухай бодож байгаа ч үгүй юм байна, гэж төслийн ажилтан Ганбаатар хэлж инээдэм болж билээ.

2012 оны өвөл, Завхан аймгийн Тосонцэнгэл сумаас Сонгино сум орох замд машин цасанд суугаад 2 цаг гаруй боллоо. Жолооч нар олс байхгүй, дээлний бүсээр татаж тэр нь тасраад, бид ч суудлын чилээг гаргасан шигээ хөгжилтэй нь аргагүй 2 цаг өнгөрөв. Гэтэл Сонгино сумын сургуулийхан сумын хаалган дээрээ гадаа 2 цаг хүлээгээд нилээд даарсан хүмүүс угтлаа. Фүкүчи багшаас дараа нь цасанд суухад сандарсан уу? гэж асуухад “ээжээ, аавaa ингээд чинь очих нь” гэж бодсон гэж билээ. Гадаа 2 цаг хүлээдэг ийм халуун дулаан сэтгэлтэй хүмүүс гэж байдгаа гээд нүднээс нь нулимас гарч билээ.

Такахата багш маань духаа алгадан босч ирээд “та нар нялх хүүхэд эхийн сүүндээ цадчихаад байхад дахин дахин өгөх гээд байх юм” гэж агуулга чинь ихдээд байнаа гэдгийг тайлбарлаад, арга зүйн хувьд “автобусанд суулгасан хүүхдээ замдаа гээлгүй, эцсийн буудал хүртэл бүгдийг авч очоорой” гэж энгийн жишээгээр хэлж байсан нь санаанд тодхон үлджээ.







## Mals.mn сайт

**Багшлахуйн хөгжлийн арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх, хичээлийн судалгааг хэрэгжүүлэх замаар ажлын байран дээрээ багшлах арга зүйг хөгжүүлэх үйлсэд дэмжлэг, зөвлөгөө үзүүлэх зорилгоор МХСН-ийн mals.mn сайтыг 2015 оны 10 дугаар сард нээсэн.**

## Нөхөрсөг шог

### Гавьяат багш Увшийн Доёд-д

*Үг цөөнтэй, дуу аядуу, даруу төлөвтэй Доёд багш*
*Үйлийн баримжаанд мэдлэг бүтээх үзэл баримталтай*
*Үйл ажиллагаар өөрөө нь хийлгэх багшлахуйн урлагтай*
*Үйлдэл бүр нь эмх цэгцтэй, сэтгэл амгалан араншинтай*





### Фүкүчи Акитэрү -д

*Суралцахуйг дэмжих төслийн зөвлөх*
*Судалгаа шинжилгээний эрхэм үйлстэн*
*Монголын судлаач, багш нарын төлөө*
*Мохошгүй хөдөлмөрөө зориулсан ачтан*

### Дамдинсүрэнгийн Энхтуяа-д

*Сэтгэмж цогцолбор сургуульдаа шилдэг менежер*
*Судалгааны нийгэмлэгтээ ажилсаг мэргэжилтэн*
*Баялаг туршлага, бахдам үйлсээрээ*
*Багшлахуйн арга зүйг дэлгэрүүлсээр явна*



## ЭРХ ОЛГОХ СУРГАЛТ

**ЗОРИЛГО:**

*Шинэ зууны хамгийн өгөөжтэй багшийн мэргэжил дээшлүүлэх арга болсон ажлын байран дээр багшлах арга зүйгээ хамтран хөгжүүлэх хичээлийн судалгаагаар удирдах, зөвлөх, хөгжүүлэх чанартай мэргэжилтэн бэлтгэх*

**СУРАЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:** Өөрийн ажлын байран дээрээ хичээлийн судалгааны арга зүйг идэвхтэй, практик үйлээр хэрэгжүүлэх замаар судлах болон багшлах арга зүйгээ шинэчлэн тодорхой шалгууруудыг хангасан нөхцөлд эрхээ авна. Болзолоо биелүүлсний дараа материалаа шалгуур тус бүрээр бүрдүүлж, МХСН-ийн экспертийн комисст материалаа, батлах нотлох баримтын хамт ирүүлнэ.

**ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ “ҮНДЭСНИЙ ЭКСПЕРТ”–ИЙН ШАЛГУУР**

1. Хичээлийн судалгааны мэргэжлийн багт ажиллаж, судалгаат хичээлийг тогтмол хамтран явуулдаг байх
2. Үндэсний хэмжээний сургалтад сургагч багшаар ажилласан байх
3. Хичээлийн судалгааны (бүс, орон нутгийн аль нэг түвшинд) мониторингод багадаа 1 удаа оролцон үр дүнтэй ажиллаж, тайлан бичсэн байх
4. Хичээлийн судалгааны гарын авлага, зөвлөмж, модуль боловсруулахад голлох үүрэгтэй оролцсон, байх эсвэл мэргэжлийн сэтгүүл, mn сайтад 1-2 материал нийтлүүлсэн байх
5. Хичээлийн судалгааны үндэсний онол практикийн бага хурлад илтгэл хэлэлцүүлсэн байх
6. Японд эсвэл бусад оронд хичээлийн судалгааны арга зүйн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх

Найргийн гэр

## Хичээлийн судалгааны нийгэмлэг

*Алс холын Япон орны*
*Ардын боловсролын арга зүйг*
*Ажил үйлсэдээ хэрэгжүүлсэн*
*Алдар түүхтэй нийгэмлэг ээ.*

***Эрдэмтэн судлаачид багш нарын***
***Эвлэлдэн нэгдсэн нийгэмлэг ээ***

*Багш судлаачид хамтран*
*Багачууд сурагчдыг хөгжүүлсэн*
*Баялаг туршлагаа дэлгэрүүлсэн*
*Бахдам амжилтын эзэд ээ*

***Эрдэмтэн судлаачид багш нарын***
***Эвлэлдэн нэгдсэн нийгэмлэг ээ***

*Судалгаа, шинжилгээ ажиглалтаар*
*Суралцахуйн үйлийг дэмжсэн*
*Хүүхэд бүхнийг хөгжүүлсэн*
*Хичээлийн судалгааны нийгэмлэг ээ*

***Эрдэмтэн судлаачид багш нарын***
***Эвлэлдэн нэгдсэн нийгэмлэг ээ***

**Шүлгийг Б.Жуваа**